



**Шоргоолжны хаант  
улсыг сурвалжилсан  
ТЭМДЭГЛЭЛ**





Лигдэн



**Шоргоолжны хаант  
улсыг сурвалжилсан  
ТЭМДЭГЛЭЛ**

Монгол бичгээс кирилл үсэгт буулгасан Д.Батжаргал



Лигдэн

## **ШОРГООЛЖНЫ ХААНТ УЛСЫГ СУРВАЛЖИЛСАН ТЭМДЭГЛЭЛ**

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Монгол бичгээс кирилл үсэгт буулгасан Д.Батжаргал

Зураач Дэнзэн

Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа

Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

## Уран үгийн вант улсын Лигдэн хаан

Уран үгийн вант улс гэж байдаг гэнэ. Тэндэхийн бийр үзэг нь босоо, бичиг үсэг нь босоо, билэг оюун нь босоо. Босоо заяатай тэрхүү вант улсын хаан сэнтийд Лигдэн хутагт залрах бөлгөө. Албат иргэдийг нь нэрлэвээс гучин гурван алтан үхэр хариулсан Гармаа хөвгүүн, урт сахлаа илэхээр ухаан нь гарч ирдэг мөнгөн сахалт өвөө, сургуульд сурахыг хүссэн бүжин туулай, тэр ч байтугай наян найман найланхай гүнжтэй шоргоолжны хаант улс хүртэл түүний харьяат болой. Уран үгээс амилан төрсөн тэдгээр баатрууд хүүхдийн сэтгэлийг гойд татдаг. Тийм сонирхолтой баатруудаар уран үгийн вант улсаа бүрдүүлсэн Лигдэн хаантны гавьяат үйлсийг БНХАУ-аас болон Өвөр Монголын өөртөө засах орноос өндөр үнэлж утга зохиолын шилдэг бүтээлд олгодог гуч гаруй шагналаа хүртээжээ.

Чингисийн алтан ургийн сүүлчийн монгол хаан Цахарын Лигдэн хутагтын суу алдар мандаж байсан өвөрлөгч нутгийн хөвөөт шар хошуунд Өлд цахар Лигдэн хэмээгч үгийн хаантан төрж, хүүхдийн уран зохиолын гүрэн улст уран үгийн хаанчлалаа тийнхүү тогтоосон нь энэ билээ.

Түүний "Шидэт толь" (1978), "Гучин гурван алтан үхрийн домог" (1981), "Ишцэрэн минь" (1985), "Шоргоолжны хаант улсыг сурвалжилсан тэмдэглэл" (1996), "Сүх, нохой, хүн" (1998) зэрэг хүүхдэд зориулсан олон сонин ном зохиогчоо тийнхүү уран үгийн вант улсын хаан сэнтийд өргөмжилжээ.

Анх танилцахад үнэхээр л хаан шиг сайхан эр золгон мэндчилж билээ. Зүүн хойт Хятадын эргийг тана сувдаар эмжсэн мэт үзэсгэлэнт Далянь хотноо бид танилцсан. Азийн хүүхдийн утга зохиолын 6-р их хурлын нээлтэд очихоор хувцаслаж байтал хаалга тогших сонсдов. Хаалгаа нээвэл алтан мөнгөн саа цацруулсан хоргой торгон дээлтэй, жанжин малгайтай жавхлантай нэгэн монгол, өөрийгөө "Лигдэн" гэж танилцууллаа. Их монголын Лигдэн хутагтын сүнс босч ирээ үү гэлтэй. Сүрэнд нь сүрдэж, бараанд нь бахархмаар. Танилцаад ирэхлээр эгэл даруу, нөхрийн жудаг сайтай, гүнддүүгүй сайхан хүн байлаа. Туурвил бүтээлтэй нь нарийвчлан танилцвал аргагүй л уран үгийн вант улсын хаан сэнтийд залармаар нэгэн байв.

Тэрээр Өвөр монголын Зохиолчдын хорооны дэд дарга, "Өнөр цэцэг" сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийн албыг олон жил хашиж, ажлынхаа чөлөө заваар нэг сая гаруй үгсийн тэмдэгт бүхий бүтээл туурвиж, аль хэдийн эрдэнэт үгсийн саятан болжээ.

Чингээд би өвөрлөгч нөхрийнхөө уран бүтээлийг монголын бяцхан уншигчдад танилцуулахаар шийдэж, хүүхдийн соёлын сангийн шугамаар уран бүтээлийн өдрүүдийг нь эх орондоо зохион байгууллаа. Юуны өмнө "Гучин гурван алтан үхрийн домог" номыг нь Улаанбаатарт хэвлүүлэн гаргаж хүүхдийн хүртээл болголоо. Уран сайхны боловсруулалт сайтай сонин үлгэр л дээ. Уншихад яруу тэр үлгэрийн цаана эх оронч сэтгэл нэвт шувт шингэсэн байдаг. Уран бүтээлийн өдрүүдийнх нь нээлт дээр ардын ерөөлч хуурдан уншихад хүүхдүүд их сонирхож байсан. Бараг л

төвийн бүх сонин, сэтгүүл, радио телевизээр Лигданий уран бүтээл, шүлэг үлгэрүүд нь уншигчдын хүртээл болсон байв. Удалгүй тэр эхнэртэйгээ хамт хүрэлцэн ирлээ. Эхнэр Шүрэнхуарых нь нэр өвөр монголын олон сурах бичгийн хуудсан дээр бичээстэй байдаг.

Лигданий уран бүтээлийн өдрүүдэд ардын зохиолч Бавуугийн Лхагвасүрэн, төрийн шагналт зохиолч Доржийн Гармаа, МЗЭ-ийн Гүйцэтгэх захирал Хайдавын Чилаажав болон нийт хүүхдийн зохиолчид, соёл урлагийн нэрт зүтгэлтнүүд оролцож хүндэтгэл үзүүлсэн билээ. Уран бүтээлийн өдрүүд нь хөдөөгийн сургууль, малчны хотонд үргэлжилж, эцэст нь Лигдэн зохиолч Монголын хүүхдүүдэд оюуны өглөг түгээсний төлөө Монголын хүүхдийн төлөө үндэсний газрын дээд шагнал сайн үйлстний алтан медаль хүртэж билээ. Удалгүй түүний “Туравдугаар гаригийн тунхаг” роман Монголд хэвлэгдэж, Лигдэн гэдэг нэр манай уншигчдад бүр ч ойр дотно боллоо. Тэр романд Хятадад болж өнгөрсөн соёлын хувьсгалын тухай өгүүлдэг. Хэцүү цагт хүний мөс чанар хэрхэн хувирч байсныг элэглэл өгөөтэй харуулсан туульсын тэр томоохон бүтээлийг манайхан сонирхож эрэл сурал болон уншсан.

Дараахан нь миний уран бүтээлийн өдрүүдийг Өвөр монголд өндөр хэмжээнд зохион байгууллаа. Энэ удаа Хятадын хүүхдийн утга зохиолын хөгжилд онцгой хувь нэмрээ оруулсан “Шоргоолжны хаант улсыг сурвалжилсан тэмдэглэл” хэмээх ном нь Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй хөдөөгийн боловсролыг дэмжих төсөлд шалгарч, монголын сургуулиудын анги болгонд байгуулах номын санд залран очиж байна. Монголын болон дэлхийн хүүхдийн уран зохиолын шилдэг бүтээлүүдтэй өрсөлдөж шалгарсан нь яахын аргагүй уран үгийн вант улсын Лигдэн хаан мөн болохыг давхар баталсан үйл явдал боллоо.

Тийнхүү шоргоолжны хаант улсад зорчих замыг Монголын бяцхан уншигчдад хүүхдийн зохиолч Долгорын Батжаргал “Би Би Би” сониноор анх нээсэн бөгөөд одоо тусгай ном болгон ширээн дээр чинь тавьж байна.

Түүхийн нэгэн үед Цахарын Лигдэн хаан Халхын Цогт хун тайж хоёр Монголын төлөө нэгэн мөрний хүч болон тэмцэж байсан бол хутагт хааны нутгаас тодорсон Лигдэн зохиолч, хун тайжийн нутагт төрсөн Дондог бичээч хоёр өнөөдөр хүүхдийн утга зохиолын талбарт хамтран ажиллах учир ерөөлтэй байжээ.

Дээдсийн өлмий бат оршиж, номын гэрэл нь гийгүүлэх болтугай!

*Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн  
Жамбын Дашдондог*

## Өмнөх үг

Газар доор юу буй. Мэдээж эрдэнэс баялаг. Эрдэнэс баялгаас үнэтэй зүйл тэнд амьдардаг амьтдын амьдрал. Сохор номин ямар гайхалтай үүр өргөө барьдаг тухай бид хүүхэд багачууддаа танилцуулж байсан. Гэтэл бүр жижигхэн шавьж тэр дундаа дэлхийн хамгийн ажилсаг, хамгийн зөвсэг, хамгийн хүчтэй амьтны тоонд зүй ёсоор ордог шоргоолжны далд ертөнцийг Өвөр монголын зохиолч Лигдэн "нээжээ".

Зохиолч маань өөрөө Сул нэрт зөгийн дүрд хувилан Шоргоолжны хаант улсыг сурвалжилсан байна. Энэхүү сонирхолтой үлгэр туужийн зарим хэсгээс арваад жилийн өмнө хүүхдийн "Би Би Би" сонинд нийтэлж байхад ном болгон хэвлүүлж өгөхийг олон уншигч хүсч байлаа. Тэдний хүсэлтийг биелүүлж чадахгүй сэтгэл гонсойн явтал Дэлхийн банк, МУ-ын БСШУЯ-ны хамтран хэрэгжүүлж буй төсөл бидэнд тусаллаа. Басхүү хэвлэлийн Интерпресс компани өнгө үзэмжтэй хэвлэж та бүгдийн алган дээр тавилаа. Таалан болгооно уу.

*Д.Батжаргал*

## **Нэг. Амь насны тангараг тавин алсын аялалд мордов**

“Бурхан тэнгэрийн тусгай томилсон элч” гэж шоргоолжныхон надад хэмжээлшгүй сүсэг бишрэлээр ёсолдог байсан ч үнэндээ би бол ердийн нэгэн нисэгч юм шүү. Миний нэрийг Сул гэдэг. Сум биш шүү. Би зөгийн хаант улсын төрийн сонины сурвалжлагчаар урьд нь нэг зуу гаруй жил ажилласан түүхтэй.

Тийм болохоор би газрын бөмбөрцгийн гадаргууд болж буй бүхий сонин явдал гайхамшигтай үлгэрийг үзэж сонсон бас маш олон сурвалжлага бичсэн. Нэн ялангуяа цэцгийн хүрээлэнгийн үлгэр түүхийг би андахгүй. Харин “Шоргоолжны хаант улс” гэдэг газар доорх этгээд сонин ертөнц байдаг гэнэ шүү гэж намайг өлгийтэй байхад намрын бороо зүсэрч, ажил зогсох бүрт миний ээж цуглуулсан балнаасаа хааяа нэг сорчихоод нойр хулжтал ярьдаг байсан.

Гэтэл тэр нь бүр энгийн үлгэр домог шиг таамаг төдийхөн яригддаг, үнэндээ чухам юу юу байдаг, ямархан сонин жигтэй улс орон гэдэг нь огтхон ч мэдэгддэггүй, ёстой үхэр чулуу шиг хатуу оньсого болоод миний бодолд зуу илүү жил хэвтсэн юм. Одоо болтол тэр үеийн ээжийн ярьдаг тэдгээр хачин сонин үлгэрийг миний өөрийн биеэр үзэж сонсож сурвалжилсан, туйлын хачирхалтай газар доорх хаант улсын сонин сайхантай адилтгах юм бол мянганы нэг хувьд ч хүрэхгүй гэмээр юм. Гэвч анхны хүсэл мөрөөдөл минь тэр үеэс үндэслэсэн юм.

Тэгээд би Шоргоолжны хаант улсаа тойрохсон гэж олон жил тэсгэл алдан бодлоо. Хэрэгт дуртай манай сониуч ах дүү нар намайг байн байн шалж, “Шоргоолжны хаант улсын нууцыг та





бидэнд сонсгож дуулгахгүй юм бол тэдний амьдралын гайхалтай сонин сайхан зүйлийг огт мэдэхгүй, балар харанхуйд шаналсан хүсэл бодолдоо амьдаараа борц болон хатаж үхэх болно. Та минь манийгаа авран өршөөгөөч” гэж сүр бадруулан гуйцгааж, зарим нь бүр нулимс бөмбөрүүлж балт ордны ханан хадан дээр түс түс

мөргөж сөгдөн гуйдаг билээ. Би гэгч сэтгэл уярамтгай, бие хөнгөн амьтан болохоор тэдэнд,

- За яахав. Та нарын гуйлтыг жинхэнээр нь хүлээж авъя. Амь насаа зольж байгаад ч гэсэн та бүхний агуу их эрхэм нандин хүсэл найдлагыг биелүүлье. Ялангуяа Шоргоолжны хаант улс гэдэг нууцын нууц далд ертөнцийг сурвалжлан бүх орчлонд илрүүлэн мэдээлэх яруу алдартай түүхэн үүргийг лавтай биелүүлэхээ тэнгэрийн оронд заларсан туйлын энэрэнгүй ачит ээжийнхээ гэгээн сүнсний өмнө бал сордог багаж хошуугаа газар шааж тангараг тавья хэмээн хэлэв.

Тэгээд би тэрхүү хүсэл мөрөөдөл, амлалтаа биелүүлэхээр маш нарийн нямбай төлөвлөгөө гаргаж, таван шөнийн турш бэлтгэл хийгээд сая Шоргоолжны хаант улсыг сурвалжлахаар мордсон билээ.

- Бяцхан найз нар минь! Миний чимээг чагнан хүлээж, маш гайхамшигтай сайхан үлгэр олж сонсохыг бат итгэн дээд тэнгэрт даатгаж байгаарай.

## Хоёр. Шоргоолжны хаант улсын хааны ордонд орохоор хал зовлон амсав

Би гэрээсээ гарч нутгаасаа алслан холдож, Шоргоолжны хаант улсыг чиглэн нислээ. Энэ улсын тухай зүйл зүйлийн аймшигтай гэнэн яриа байдаг болохоор аяллын алхам, нислэг бүртээ сэрэмжилж явлаа. Шоргоолжны хаант улсын нийслэл нь чухам хаана байдгийг би мэдэхгүй билээ.

Хол замд өлсөж ундаасч, ядарч зүдрэхийг хүлцэн тэсвэрлэшгүй таван жилийн хугацаагаар ертөнцийн агаар дээгүүр олон удаа эргэлдэн ажиглалт хийлээ.

Гэнэт миний нүдэнд олон мянган улаан шороон суварга үзэгдлээ. Би олон жилийн туршлагаараа энэ яах аргагүй нэг чухал газар гэж таамаглаад дээрээс нь ажиглалтал тэр улаан шороо нь суварганы хавиар гэнэт нэгэн сонин үзэгдэл анхаарал татав. Юу хэмээвэл, тэр улаан шороон довцгууд үерлэн нүүдэллэж байх нь харагдав. Би алмайран гайхлаа.

“Нар цацарсан ийм сайхан өдөр, ойр орчинд бороо хур буугаагүй байхад юу ингэж үерлэн нүүдэллэдэг билээ. Эдгээр улаан суваргууд хөлтэй гэж үү?” хэмээн улам лавшруулан хартал, харин тэр нь олон мянган шороолж том том улаан шороо бөөмнүүдийг нарийн нуруун дээрээ ажиг ч үгүй үүрээд суварга босгохоор явж байгаа зөөврийн урт жагсаал байсан юм санжээ.

Тэдний нааш цааш зөрөлдөн шурд шард, шурд шард гүйлдэж урамтай, омогтой, баясгалантай хөдөлмөрлөж байгааг үгээр дүрслэхийн аргагүй. Би сонгож сонгож нэгэн өндөр суварганы



орой дээр буугаад суварганы хормойгоор том том бөөм шороог  
янцаглан зөөж суваргалан давхарлаж тавиад, дор нь амарч  
байсан тавдугаар хөл нь муруй нэг шоргоолжийг далавчаараа  
ёслон даллаж дуудлаа.

-Эрхэм таны улсын хааны ордон чинь хаана байна? гэж асуулаа. Муруй хөлт шоргоолж наашаа нэг муухай харснаа гэнэт цочисхийж,

-Чи чухам хаанаас ирсэн чөтгөр шиг муухай дүртэй амьд махан хүнс вэ? Манай хааныг сураглаж яах гэв? Манай хааны махыг маймрах (идэх) гэж горьдоо юу? хэмээн маш их хорсолтой асуув.

Би түүний үгийг сонсмогц айдас хүрч аюулыг түр ч гэсэн зайлуулахыг оролдлоо.

- Үгүй, үгүй. Би танай хаанд бараалхаж амрыг айлтгахын хамт хамгийн амтат идээ хаана байгааг сонордуулахаар ирсэн юм муруй хөлт ноёнтон минь гэв. Муруй хөлт намайг итгэж ядсан харцаар хялайж хараад,

- Чи чухам ямар хийгээ тавьж байна. Хэлсэн чинь үнэн үү? гэж маш их дээрэнгүй дуугарав. Би хирдхийж айснаас болоод аяыг нь дагуулан эелдгээр хариулж байв.

- Үнээн, үнэн. Хүндэт муруй хөлт гуай минь.

- Нэр чинь хэн бэ?

- Сул.

- Сум гэнэ үү? Элэнцэг чинь. Манийгаа харвахаар ирэв үү?

- Биш ээ биш. Сум биш Сул.

- Аа, тийм үү? Нас чинь хэд буй?

- Нэг зуун гучин тав.

- Пээ, харла. Авгалдайнаасаа саяхан мултарч гарсан нялзрай шив.

- Хүндэт настан таны нас сүүдэр хэд болоо буй?

- Залуу, Залуу! Дөнгөж дөрвөн зуун дөч болж байна. Чи юу гэж ийм улаан нялхаараа ингэж тэнүүчлэн маньд бэлэн зууш болохоор ирэв ээ?

- Би бол Зөгийн вант улсын сурвалжлагч юм. Эрхэм улсын хаанд бараалхах санаатай.

- Амны салиа арилаагүй муу хэдгэнэ чи, амандаа багтахгүй их юм чалчиж байна даа. Бөгсөндөө хүрэхгүй гараа тэнгэр өөд сарвайгаад аймшиггүй донгосно гэгч энэ биз.

- Үгүй. Манай ван намайг томилсон юм. Би вангийн зарлигийг гүйцэтгэж явна.

- Гэрч юу байна?

- Эрхэм ноёнтон минь, энэ байна.

- Юу? Энэ чинь цэцгийн нэгэн ялтас биш үү?

- Тийм. Би бол Цэцгийн хүрээлэнт улсын балт зөгий. Тиймээс бид албан бичгийг анхилам үнэрт цэцгийн ялтас дээр бичдэг байхгүй юу.

- Энэ бичгийг чинь чухам яаж уншдаг юм?

- Үүнийг би ирэхээсээ өмнө бэлтгэсэн. Хэрвээ аян замд аюул тохиолдвол аманд ойртуулна гэж амттан шингээсэн цэцгийн ялтас юм. Энэ бал гэгч ямар ч амьтныг дотроос нь уяруулан хайлуулдаг увдистай. Та үнэмшихгүй байгаа бол наад ялтсаа уран хэлээрээ долоогоод намбатай сайхан тамшаалаач гэв. Муруй хөлт маш хичээмтгийгээр хэлээ цэцгийн ялтаст хүргэж тамшаалаад тэсгэлгүй дуу алдаж,

- Хай, ямар сайхан юм бэ? Ийм юм бас байна аа гээд үгээ хэлж гүйцэлгүй өнөөх цэцгийн ялтсыг зажлалгүй залгичхав.

- Би энэ удаа эрхэм таны өршөөлөөр хаан эзэнтэй золгочихвол дараа ирэхдээ түмэн шороолжны чөрхлөө тэргээр хүргэж ирье.

- Тэгвэл чи манай улсын ёсоор нэгдүгээр хөл дээрээсээ нэг үс үгтээж хаяад бурхан тэнгэрт амлалт өгөх үү?

- Тэгэлгүй яахав. Агуу их шоргоолжны хаанд бараалхах юм чинь, эрхэм улсын аливаа ёсыг дуртай дагана. Тэгээд би нэгдүгээр хөл

(Тэд баруун гар талын өмнөөсөө эхэлж олон хөлөө дугаарладаг заншилтай) дээрээс нэгэн ширхэг хар үсээ шүд зуун үгтээж хаяад тэдний шаардлага ёсоор,

- Эдүгээ тэр бурхан тэнгэрийн өлмий дор тонгос тонгос мөргөж үнэнч хичээнгүйгээр ам алдах нь:

- Би чин сэтгэл, сүсэг бишрэлээрээ эзэн хаанд ёслол мөргөж бараалхахыг гуйнам. Хэрвээ эзэн хааны алтан биеийг хөндөх буюу ундууцал хилэнг хөдөлгөөл тэрхэн даруйд нь өчүүхэн сурвалжлагч намайг энэ үс мэт амьдралын арьс хөрснөөс үгтээж хаягтун хэмээн тангараг өргөв.

Муруй хөлт шоргоолж гэгч уул нь Шоргоолжны хаант улсын Ус сэргийлэх яамны захирагч ноён байжээ. Тиймээс тэр доорх хэдэн зарцаа дуудаж миний нүдийг шинэхэн хуулж авсан модны хуулдсаар боогоод хэсэг явж ордны хамгийн гадна хаалганы харуулд тушааж өглөө.

Тэр нь мөн л муруй хөлт жанжин шиг ам өчгийг нь аваад хоёрдугаар хөлөөс минь хамгийн хайртай хамгийн урт үсийг үгтээлээ. Энэ мэтээр нийт наян нэгэн хаалга дамжлаа. Дөч, тавьдугаар хаалга зүтгэж дамжих үед хамаг бие минь өвдөөд, нүд харанхуйлан, чих шуугин амьд тамын ёроолд унаснаа санаж эрүүл ухаанаа алдав.

Би хэрэгт дуртай сониуч зангаасаа болж ийм зовлонд унасандaa гэмшээд үе үе уйлж явлаа. Гэвч замын дундаас буцвал нэр нүүрээ барна гэж бодохдоо нулимс дуслуулан дөрвөн шоргоолжоор сугадуулан урагш зүтгэж явлаа. Сүүл сүүлдээ миний бүх мэдрэл алдарч дотор харанхуйлан нутагтаа амь голтой буцна гэдэгт горь тасарч билээ. Хамгийн сүүлчийн боомтыг чухам яаж туулснаа бодоод бодоод олдоггүй юм. Ёстой л там тууллаа.

Намайг нэг хаалга өнгөрөх бүрт миний хайртай хар үснээс албаар нэгийг үгтээж үс нэг бүрийг тэр даруйд нь нэг нэг шоргоолж тосч аваад нуруун дээрээ уртааш нь үүрээд цувран дагаж явлаа.

Наян нэгэн шоргоолж наян нэгэн үсийг минь үүрээд миний

араас дагаж хааны ордонд орсон билээ. Энэ нь чухам ямар учиртай болохыг хааны ордонд орон ортлоо би огт мэдээгүй байсан. Ямар ч гашуун зовлон төгсгөлтэй байдаг гэдгийг би тэр удаа гуйвшгүй мэдсэн юм. Би шүдээ тас зууж явтал бодол зүүдэнд ч оромгүй юм болж миний нүдний боолт алдран хачин сонин ертөнцтэй золголоо.

Хааны ордны хамгийн дотор талын хүрээлэнд орчихжээ. Зориг орж сэтгэл сэргэлээ. Аюулгүй амгалан үүд хаалга нь чухам хаанаа байгаа нь үл мэдэгдэн аварга том агуйд оржээ гэдгийг би сэмээрхэн таамаглалаа. Би өөрийн мэдэлгүй тэдэнд илжиг шиг хөтлөгдөөд бас нэг хэсэг явтал өмнөөс гэнэт хурц гэрэл гялсхийв. Би айж цочсон харцаар эргэн тойрныг ажиглахад улаан, ногоон, шар, цагаан, ягаан, бүгээн гэрэл өнгө өнгөөр ялгаран миний нүдийг гялбуулав.

Тэдгээр сонин эд агуурс өнгө өнгийн эрдэнэ шигтгэсэн хана нь хүн гэдэг гозгор амьтны хэлдэг алт мөнгийг бодвол ёстой жинхэнэ эрдэнэс гэдэг тэр байлаа. Би ийш тийш харж мэлэрсээр нэг мэдэхэд хааны ордны хамгийн дотоод харшийн гадаа хаалганд ирчихсэн билээ.

Өөрөөр хэлбэл, наян нэгдүгээр хаалга нь тэр юмсанжээ. Шоргоолжны хааны ордон гэгч их хүрээн дотор бага хүрээ, бага хүрээн дотор жижиг харш, жижиг харш дотор баатар хаан хатантайгаа энх амгалан саатдаг юмсанжээ.



## **Гурав. Хааны ордны хаалганы өмнө амандаа хөндлөн өвс зуугаад хэрэн зогссон бүлтгэр харуул**

Би хааны ордны хамгийн дотор талын бяцхан харшийн хаалганы гадна өөрөөр хэлбэл, наян нэгдүгээр хаалган дээр ирээд дотогш орох гэтэл амандаа хөндлөн өвс зуусан бүлтгэр шар шоргоолж сүвээ тулан өөдөөс хөндөлдөн харж зогслоо. Би өөрийн мэдэлгүй арагшаа ухасхийн цочих зуур ажиглан харвал, шоргоолжны бүлтгэр хар нүд нь гал мэт улалзан, өдөлсөн сум шиг туйлын хилэн хорсолтой гялалзан байлаа.

- Зогс! Аймшиггүй муу эрээн чөтгөр гэж бүлтгэр шар шоргоолж омогтой зандрал. Би зогтусан дахиад ямар зарлиг цааз буулгахыг хичээн чагналаа. Тэгж байтал намайг дагуулан ирсэн шоргоолж,

- Энэ бол Зөгийн вант улсаас манай улсад хүнсний явдалд гавьяа байгуулахаар томилогдож ирсэн эрээн гэдэст элч гэнэ. Бид хааны хууль ёсоор наян дамжлага дамжуулж мөргөл өргөл гүйцэтгүүлэн авч ирлээ гэж амаа ихэд тамшаалан өчив.

- Тийм үү, хэрвээ чи худал хэлээд мэдэгдвэл ийм болно гэдгийг эртхэн мэдээрэй гээд бүлтгэр шар харуул амандаа зуусан өнөөх хөндлөн өвсөө үүдэн шүдээрээ тас хазан хоёр хэсэг болгов.

- Ноёнтон минь, тэг тэг. Өчүүхэн элч үгэндээ лавтай хүрнэ гэж хэлэхэд, Бүлтгэр шар харуул,

- Тийм бол энэ золигийн наян нэг дэх үсийг үгтээ гэж зарлиг болмогц үүдний гадаа сүр болж зогссон дээд уруул нь дэндүү их сэтэрхий хоёр хар шоргоолж гүйлдэн ирээд миний замдаа аргалан нууж, далдлан хамгаалсаар эдүгээ хүртэл мэнд авч ирсэн баруун хавирганы дээд талд байсан наяд жилийн настай халиурсан



хар үсийг минь байз гэхийн завдалгүй суга татав. Бүлтгэр хар шоргоолжны бах нь ханасан мэт,

- Ёолохоо мэдсэн бол юунд саваагүй явдал сэдэж савсаганана вэ? Хи хи гэж завжаараа шүлсээ дуслуулан байж хэлэв. Түүний шүлс чухам яахдаа гүрд гүрдхийтэл залгиж байвч тэгж хэцүү

савираад байна гэдгийг би тэр үед гайхаж билээ. Гэхдээ энэ мунхаг толгойд минь түүний дотор ямар нэг онцгой шалтгаан нуугдаж байгаа болов уу гэдгийг бодох ухаан орсонгүй.

Намайг батлан дагаж, сэрэмжлэн сэргийлж, хамгаалагч нарыг ахалж яваа туранхай шоргоолж яс амарлаа гэсэн шиг эвшээлгэсээр,

- За, за. Одоо бүх л дамжлага гүйцлээ. Наян нэг дэх үс үүрсэн шоргоолж хамгийн ард ёс номтой дагаж мөргө гэж албархуу хэлэхэд бүлтгэр шар харуул том үүдээ хоёр тийш нээж биднийг орууллаа. Хаалга нээгдмэгц миний өмнө цахис цахис цагаан гэрэл харван, нэлс нэлс ногоон гэрэл татан, цэхэс цэхэс цэнхэр оч бадраасан ер бусын ертөнц угтлаа. Би тэр дороо нэг их аймшигтай соронзонд татагдсан мэт мэлэрчихэв. Ордны зүүн, баруун хоёр талаар найлзуур бургас шиг сунайсан сунайсан биетэй хар шоргоолжнууд эгнэн зогссон үзэгдэв.

Тэд зүүн талын нэгдүгээр хөлөө урагш муруйлган сунгаж ёслол угтаж байгаагаа илэрхийлдэг аж. Хоёр талаар эгнэн зогссон нь ордны ёслолын шадар анги гэнэ. Улсын бүх нүхнээс сонгож шалгаруулан авчирсан гоо хээнцэр охид байлаа. Миний харц өөрийн эрхгүй татагдан үсээ үгтээлгэсэн гашуун зовлонгоо мартсан билээ. Замлагч маань намайг удирдан урьдаар ёслол тахилгын ерөөнд хүндэлж орууллаа.

Би яг тариачин өвгөнд хөтлөгдсөн номхон илжиг шиг дуу шуугүй гэлдэрч байв. Намайг хүндлэн нэгэн том агуйд оруулж ханан дээр өлгөсөн арзгар юмны өмнө аваачиж мөргүүлэв. Мөргөж дуусаад ажиглаж харвал хатаасан шоргоолжны араг яс байлаа. Тэр нь хамгийн дээд шүтээн өвөг дээдсийнх нь шарил гэнэ. Намайг тамлаж үгтээсэн өнөөх наян нэгэн үсийг сайхь дээдсийн шарилын өмнө овоолж тахилаа. Энэ бол тэдний зан үйл юмсанж. Ингэж тахиад гурав хоносны дараа хаан, хатадтайгаа өглөөний цайндаа зуушилж зооглодог байжээ. Өнөөх догшин ширүүн бүлтгэр шар харуулын харц нэг учиртай байгаад байсан нь миний үсийг ингэх учиртай байжээ.

## **Дөрөв. Шоргоолжны хааны наян наймдугаар наалинхай хатантай уулзаж ярилцсан минь**

Би хааны ордонд орж угтлагын ёслолд оролцсоны дараа хаантай уулзъя гэсэнд ордны доторх олон түшмэлийн дотор онцгой өндөр байртай хааны хамгийн итгэмжтэй, хавчганаан алхдаг нэгэн түшмэл надад,


- Манай хаан нойрсож байна. Та хүлээж байгаарай гэв.
- Хэдүй удаан хүлээвэл хаан дээшлэхсэн бол?
- Өнөөдөр сая нойрссон. Гутлаа дэрлэсэн юм чинь гурван жилээс наашгүй гэв.

Шоргоолжны улсын заншлаар улс гэр нь амар төвшин байгаа үед хаан нь бүх улсын ажилч баатар шоргоолжоо төлөөлөөд сэтгэл тайван нойрсох ёстой гэнэ. Улс их амгалан бол гутлаа дэрлээд гурван жил нойрсдог, бага амгалан бол зүүн талын нэг хөлөө дэрлээд зүүрмэглэх төдий болоод зүг зүгээс авчирсан нарийн нуруут бүжигчидтэй наадсан шиг байдаг гэнэ. Барцад гамшигтай бол баруун нэгдүгээр хөлөөрөө бавайсан сахлаа байн байн имрэн зарлиг буулгаж суудаг гэнэ.

- За больё. Хаан дээшилтэл хүлээх юм бол гурван жил болно. Таньж мэдэхгүй энэ газар идэж уух таарахгүй, илүү хөдөлж болохгүй, инээж тоглож ч болохгүй их зовлонтой гэж бодоод хавчгануур түшмэлд учир байдлаа тоочтол,

- Та урьдаар сул хаадтай уулзаж өдөр өнгөрүүлж бай л даа гэж арга алдарсан янзтай гонгинолоо.

Хавчгануурын дохилтоор ордны агуйн булангийн өрөөнөөс нэгэн нарийн урт хар шоргоолж зураг дээр гардгаасаа зуун хувь сайхан зургаан хөлөөрөө аршийн уулнаас туналзан урсах рашаан



булгийн ус мэт нахис нахис найгалзан, намирсан нүүдэл алхаагаар гарч ирлээ.

Түүний тэр нахилзан гунхсан алхаа гэж ёстой уран бүжгийн хөдөлгөөнөөр биелж байхын адил сонин. Зургаан нарийн хөлөө

яг зэрэгцээ шугамаар, хоёр мөрлүүлэн гишгэж хэмжээ алдахгүй зөөж тавьсаар ирэв. Бусад амьтанд байшгүй эрдэнийн хар алмазаар бөмбийлгөн сийлж урласан мэт гялтганасан хар нүдээ гэрэлтүүлсээр бие дээрх нимгэн хар хилэн торгомсог ууж өмссөн мэт, нарийн зөөлөн ширхэгт ноолууран даашинзаа гөлтгөнүүлэн гялалзуулсаар ирлээ. Гурван сайхан уруулаа хумисхийгээд, гоё зүсээ гэрэлтүүлсээр ирлээ. Би бүр мэлэрчхэв. Нуулгүй хэлбэл Шоргоолжны хаант улсад бас ийм сайхан үзэсгэлэн гоо дагина байдаг байжээ гэж дотроо гайхаж бишрэн дурлахын туйлд хүрэв. Энэхүү гоо үзэсгэлэнт дагина Шоргоолжны хааны наян наймдугаар наалинхай хатан юмсанжээ. Хавчгануур түшмэл биднийг танилцууллаа.

Тэдний уулзалтын заншил манайхаас өөр юм. Эхлээд уулзахдаа хавиргаа шөргөлдүүлээд, дараа нь гуравдугаар хөлийн тавдугаар хуруу (Үнэндээ хуруу биш юм. Би л тэгж төсөөлөн нэрлэж байв)-гаараа түр зуур гохдолцоод, ёсорхог хөнгөн угзраад, аяархан тавьдаг байжээ. Бид мөн тэр ёсоор уулзав. Тэгж хөл атгалцан байх наалинхай хатан над руу цорвойж "Шал, шал! Гурд, гурд! Хос, хос!" гэх авиа гарган үг асууж байх шиг болов. Би бүр мэл гайхаад ухааныг ололгүй түгдрэн сандрахад, хажууд байсан хавчгануур түшмэл:

- Хатагтай тантай мэндлэн ордны доторх үгээр амар асууж, иддэг уудаг юм элбэг үү гэж байна хэмээн хэлмэрчлэв. Шоргоолжны хаант улсын уулзах мэндлэх ёсны хамгийн дээд хүндэтгэлийн үг нь "Иддэг, уудаг юм элбэг үү?" гэх эрт дээрээс уламжлагдан ирсэн ордны хэвшмэл үг юмсанж. Мэндлэн золгосны дараа тус тусын заагдсан суудалдаа суугаад ярилцлаа.

- Эрхэм та хаанаас алжааж (морилж гэсэнтэй адил үг) ирэв?

- Би Зегийн вант улсаас дэгэн дэрвэн ирлээ. Би Зегийн вант улсын сонины сурвалжлагч Сул гэгч байна.

- Та ямар эрхэм нандин зорилгоор дээлээ нимгэртэл дэвэргэнэ вэ?

- Балар мунхаг балт зегий би баатар мэргэн эрхэм улсыг

бахархан үзэж нүд нээхийн дашрамд хамгийн амтат хүнсний хаана байгааг хэлэхээр ирсэн билээ.

- Ээ хөөрхий, тийм үү? Таны ариун цагаан бодлыг бурхан тэнгэр өршөөг! Ингэхэд таны ван чинь хэдэн хатантай вэ?

- Манай ван нэг хатантай.

- Үгүй, чи үнэн хэлэв үү? Нэг юм уу, нэг түм юм уу?

- Нэг нэг. Нэг хоёрын нэг.

- Пээ, ёстой итгэшгүй явдал. Нэг улсын хаан гэж байгаа. Манай хаан гурван мянган хатантай. Би бол наян наймдугаарх нь. Би хоёр жилийн өмнө хаантай нэг уулзсан гээд нүдэндээ гуниг тодруулан,

-Би хэдийгээр хааны хатан гэдэг нэртэй боловч үнэндээ бол боол зарцад хүрэхгүй шүү гэж зовлонгоо тоочиход нулимс нь бүр хэлхээ тасарсан сувд мэт бөмбөрлөө.

Наян наймдугаар наалинхай хатан нь нэг вангийн гүнж байжээ. Тэгээд таван жилийн өмнө хаан нэг удаа хүнсний зузаатгалыг шалгах аар явахдаа авчирсан гучин хоёр гоо гүнжийн дотор энэ хатан "наймдугаар гоо сайхан" гэж дугаарлагдаж байв. Энэ хүүхэн шоргоолж нутагтаа байхдаа нэгэн ангийн өндөг зөөгч ажилчинтай сэтгэлтэй болоод байж гэнэ. Эрхэшгүй эзний зарлигаар энд ирснээс хойш өдөржин өнөөх өндөг зөөгчөө санаж, мөрөөдөлд уйтгарлан нүд дүүрэн нулимс гүйлгэнүүлэн суудаг гэнэ. Тэгж гуныж гутран суухыг нь хаан нэг өдөр үзээд хилэн төрж уг нь наймдугаарт дугаарласан хатны байрыг арван нэг дахин доошлуулж, наян наймдугаар болгожээ.

## **Тав. Хүндэтгэл бишрэлийг соронзон адил татагч эрх эзэмшлийн ноён оргил болж гялалзсан шоргоолжны хааны сүр ихэмсэг лагшин дүрийн тухай**

Би дотоод ордонд ороод хааны нойрссон гурван жилийн хугацаанд наян наймдугаар наалинхай хатантай дүнгэр дүнгэр ярилцаж, дүрэн дэрэн наадан, ажин түжин завсарлан, хангинатал дуулан, хайвтал бүжиглэн, хадаатал инээлдэн, их дотно дасал боллоо. Тиймээс миний сурвалжлага овоо урагштай болж сонин сайхан чимээ сонсох гэж миний араас саравчлан харж, чих дэлдийлгэн хүлээж байгаа эх орны сая сая бүлтгэр, дэлдгэр найз нартаа баяртай бардам очиж, сонин хачин явдлуудыг цувруулан мэдээлэх итгэлтэй болсон билээ.

Наян наймдугаар наалинхай хатан надтай танилцан дасалцсанаас хойш олон сайхан шагайгаа шөнийн од шиг асгаж надтай морь уралдуулан, бэрх орхижнааддаг байв. Шоргоолжныхон олон янзын амьтны шөл уудаг болохоор шагай гэж ёстой уул шиг овоолоостой байдаг юм. Тиймээс тэдний хүүхдүүд бүр багаасаа шагай орхиж нааддаг байхгүй юу.

Би хатантай наадаж өдөр өнгөрүүлдэг болсноос хойш гурван жилийн хугацаа годилт сум мэт хурдан өнгөрлөө. Нэг өдөр гэнэт хавчгануур түшмэл миний хажууд хавчганаж ирээд их урамтай нь аргагүй хоолойгоо засаад,

- Манай хаан эзэн дээшиллээ. Та одоо бараалхаж болно гэж мэдэгдэв.

Хаантай уулзах цаг боллоо гэдгийг сонсоод би маш их баярлан баруун, зүүнээ олохгүй болчихов. "Малгайгаа өмсөх гэж байгаад магнагаа өмсөв" гэгч боллоо.





Би тэр дороо хаанд бараалхах бэлтгэл хийгээд хавчгануурын дуудлагаар гадны хүндэт зочдыг хүлээн авч уулздаг хааны харшид орлоо. Би хаалгаар дотогш ормогцоо том хавтгай гялтганасан чулуун ширээн дээр олон хөлөө арзайлган, туйлын ихэмсэг суугаа

шоргоолж хааны дүр манантсан болор шилний цаана бүртэлзэхийг олж харлаа. Догдлол ухаан алдуулдаг юм байна. Нүүр чинэрэн гэнэт хоёр нүднээс минь усан болор хэлхээ тасарсан сувд мэт халуу асган буухад дотор тунгалагшин саруулсаад явчихлаа.

Олон жилийн турш шоргоолжны хаан чухам ямар янзтай байдаг бол, үзэх юмсан гэж бодож байсан минь ингэж биелдэг байжээ гэхээс сэтгэлийн догдлол багтаж ядна. Гэвч биеэ чадан ядан барьж, тэдний ёсоор хааны өмнө хүрээд, дөрвөн хөлийн өвдгөө газар тулан ёслон мөргөж, гуравдугаар хөлийн тавдугаар хуруугаараа гогдолцон, гар атгалцахын төдий болов. Тэгээд би сая эзэн хааныг эгцлэн харах зориг орж ажиглавал төгрөглөсөн том нүд нь хоёр шанаан дээрээ хагас шигтгэсэн болор шилт бөмбөг шиг гэрэлтэн, дундуураа оноотой дээд хоёр уруулын хоёр хажуу уруу гурав мушгиран эрчилж ургасан үзэмжит хар сахал нь угалзран, бие дээрх хар үс нь сайхан зуншлагатай жилийн хялгана мэт халиуран, палигар бор шүд нь төмөр цүүц мэт эрслэн жигдэрнэ. Харин нэг бодлын ээдрэл гэвэл хүндэт хааны хамар нь чухам хаана байгааг би олж харсангүй. Тэр үед нарийн шинжиж байх зав чөлөө үнэндээ гарсангүй.

Хаан эзэн нь энгийн шоргоолжноос том, ялангуяа нүд нь бүүр том, сахал нь угалзран мушгирсныг үгээр дүрслэхийн аргагүй гоё. Хаан ширээн дээр саатан байхад нь өмнөөс нь харвал айдас хүрмээр сүртэй. Би олон амьтны хаант улсаар орж гаран сурвалжлага хийж явахдаа ийм сүртэй ихэмсэг хаантай нэг ч удаа тохиолдоогүй. Олонх эзэн хаан бүр мариалаг, бөмбөгөр, өнгөлөг байдаг. Гэтэл шоргоолжны хааны бүх бие нь хар зандан модоор сийлж хийсэн мэт булчин шөрмөс нь гүрийгээд, усанд дэвтээсэн олон олон хар орс дээсийг зүг зүгт нь салаалуулан тэлж гөрсөн мэт хачин эрчлэг, шөрмөслөг харагдана. Баяр догдлол дунд толгой мэхийн ёсолж,

- Туйлын хүндэт найман түмэн, найман мянган, найман зуун наян найман настай эзэн хаан та амгалан саатаж байна уу? Манай ван таны энх амгаланг айлтгаж байгааг би өвдөг даран, амрыг эрж дамжуулья гээд яг л хүүхнүүд банзлаа өргөсхийн, нахисхийн амар

эрдэг шиг далавчаа хумисхийн байж амар эрлээ. Газрын энхрий хөвгүүн (Хүн төрөлхтөн эзэн хаанаа тэнгэрийн хөвүүн гэдэг шиг шоргоолж улс газар доор байдаг болохоор хаанаа газрын хөвгүүн гэж өргөмжлөн дууддаг байжээ) өндөр өршөөл үзүүлэн, алтан ам нээж,

- Холын зочин сайн уу гэж миний мэндийн хариуд эрхэм нандин нүүр тал хайрлав. Би хааны мэндчилгээг сонсоод баярлан,

- Сайн. Эзэн хаанд хүндэтгэн баяр хүргэж байна гээд хариу өчих гэтэл хаан эзэн нь эрдэнийн мутар (эрдэнийн хөл)-аа өргөн зангаж,

- Пас пас гэв. Би ухааныг нь олж ядан түдгэлзэхэд хажууд нь байсан хавчгануур түшмэл,

- Газрын энхрий хөвгүүн танд өршөөл хайрлаж байна. "Пас" гэдэг бол манай хааны ордны "Суу" гэдэг үг гэж их л уриалгахан тайлбарлаж өглөө.

Би шоргоолжны хааны суу гэж зааж өгсөн жижигхэн, бөмбөгөр, чийглэг чулуун дээр (тэр нь сандал гэнэ) суугаад эзэн хаан чухам ямар хувцас хунар, эдлэл хэрэглэлтэй бол гэж сонирхон шинжлээ. Тэгсэн чинь эзэн хаан шинэ хувцас өмссөнгүй, шав шалдан сууж байв. Тэрхэн зуур би өөртөө итгэсэнгүй, лавшруулан харвал үнэхээр усанд ороод гэртээ сууж байгаа мэт байлаа. Миний төсөөлснөөр хаан булган дээл, үнэг, ирвэсний арьсан нөмрөгтэй сууж байх ёстой. Тэгсэн чинь харин шал өөр эсрэг юм боллоо.

Хэдийгээр хажууд чинь ширээн дээр таних танихгүй амьтны арьс хөрс, хальс, холтсоор хийсэн хувцас харагдавч биен дээр нь ширхэг төдий халхалсан зүйлгүй нүцгэн биеэрээ байлаа. Улсын хаан байгаад ингэдэг юм уу гэж хэлмээр санагдан миний инээд хүрч тэсгэл алдран байсан ч гуяа сэмээрхэн чимхэлж, биеэ байн байн сэрэмжлүүлснээс арай л пис хийтэл инээчихсэнгүй. Тэгж байтал хаан эзэн наашаа харж, надтай үг солилцмоор байснаа гэнэт миний хөдлөл байдлаас ажиг авсан янзтай,

- Би эрхэм таны нимгэн нүүрний өмнөөс улайтлаа чимхүүлж

байгаа гуяны чинь төлөө өр өвдөж, буруугаа хүлээе гээд цааш харж суув. Миний дотор пал хийгээд явчихлаа. “Энэ чинь арай надтай уулзахаа татгалзсаны дохио биш биз” гэж бодоод хоолой дээр мөс тээглэсэн мэт болов. Би одоо яадаг билээ. Шоргоолж хааны хачин хөдөлгөөн зан араншин саяын хэлсэн үг зэргийн утгыг ололгүй гайхаж чухам ямар учир шалтгаантайг мэдсэнгүй.

Ийнхүү мэл гайхан байтал харшийн үүд гэнэт нээгдэж олон түшмэл газар шагайсаар сарвалзан арвалзан орж ирлээ. Ээ, бурхан тэнгэр минь. Энэ чинь юу болж байна аа?

## **Зургаа. Тэдний уулзалтын мэндчилгээний ЭТГЭЭД ХАЧИН ЗАНШИЛ**

Би айж цочин, эзэн хааны нурууг харж байснаасаа олон түшмэл бачимдан сандарсан янзтай шогшин орж ирснийг анзаараагүйдээ бүүр ч их айлаа. Тэр хоромд би яахаа мэдэхгүй болов. Үүсч байгаа үзэгдлийн учир шалтгааныг ухаж мэдэхгүй тархи толгой дүйнгэтэн уймрав.

Шоргоолжны хаан нь харин гярхай амьтан байжээ. Миний гуяа чимхсэнээс болоод аливаа учир хэрэг дэгдэж, хаан эзэн уурласан хүүхэд шиг тонтогнож, нүцгэн биеэ цааш харуулан суужээ. Тэгээд би хажууд байсан хавчгануур түшмэлээс,

- Эзэн хаан юуны учир хилэгнэв? хэмээн асуувал цаадах нь,

- Таныг угтаж уулзахдаа манай улсын заншлаар үнэнч шударга байхыг хамгийн дээд зарчим болгосон юм. Гэвч хаан хувцсаа тайлж, өөрийн үнэн дүрс байдлаа далдлалгүй ил үзүүлсэн боловч ар биеэ үзүүлэхээ мартчихжээ. Иймээс таны инээд хүрч, өөрийн гуяа чимхсэнийг хаан ажиглаад “Энэ лав миний ар биеэ үзүүлэхээ санамсаргүй мартсаныг санаатай нууж байгаагаар ойлгосон юм байна” гэж бодоод нэг талаар хилсээр шийтгүүлсэн таны гуяны өмнөөс уучлал гуйж, нөгөө талаар өөрийн дутагдлаа засаж ар биеэ үзүүлж, үнэнхүү юугаа ч нуухгүйгээр ил цагаанаар уулзан танилцахаа илтгэж байна гэв.

Би хавчгануур түшмэлийн нарийн тодорхой тайлбарлаж өгснийг сонсоод, тэдний онцгой, заншлыг мэдэрч, дотор бага зэрэг уужирсан ч өөрийн бүдүүлэг тэнэг, учир ёс ойлгохгүй инээд алдаж, тавьтаргүйтсэндээ гэмшив.

Би тэдний хачин сонин зан заншлын өмнө арга ядан хөл алдмаар байхыг тэргүүн сайд хавчгануур түшмэл олж үзээд,



- Айж бачимдах хэрэггүй, та бас хувцсаа тайлаад хариу ёсолбол хоёр талаараа бүр ч үнэн сэтгэлээр уулзалт хийсэн, жинхэнэ нөхөрсөг ёсны дээд утга агуулгатай харилцаа болох болно гэж хэлэв.

Би нэг талаас айж сүрдэж, нөгөө талаасаа олны өмнө яаж хувцсаа тайлдаг билээ гэж ичиж зовохын туйлд хүрэв. Гэвч усыг нь уувал ёсыг дагадаг жамтай хойно, яалтай билээ. Хэргээ гүйцээхийн төлөө өөрийн өчүүхэн ичингүйрлийг таягдан хаяхаас өөр замгүй болов. Эргэн тойронд байсан бүх түшмэл хувцсаа тайлаад шав шалдан болсон байлаа.

Би арга алдарч “Хаана явбал тэр газрын ёсыг дагана” гэж хэлдгээ санаж, олон хувцсаа тайлахаар шийдэв. Гэвч олны өмнө тайлна гэхэд зориг шантраад байлаа. Ерийн цагт унтахаар хэвтэх, биеэ угаахад байз гэхийн амжилгүй тайлчихдаг хувцас минь, одоо олны өмнө тайлна гэхэд бие дээр минь цавуугаар наасан юм шиг, эсвэл өөрийн арьснаас нэг давхрыг салгаж байгаа юм шиг гашуун зовлонтой хүнд нүсэр санагдана. Энэ улсын дотоод ордонд орох 81 хаалга дамжин үйлээ үзэж, үсээ түүлгэж байснаас ч хүнд санагдана.

Хавчгануурын хэлж байгаа хувцас тайлж уулзах ёс хийгээд түүний гүн утга агуулгыг би ойлгоно. Би бас элгэмсэг уулзалтад улаан зүрхээрээ уулзвал сая үнэнхүү нөхөрсөг уулзалт болох ёсыг мэднэ. Хавчгануурын хэлэх нь зөв. Наад зах нь нүцгэн биеэрээ уулзаж чадахгүй байгаад юуных нь улаан зүрхээрээ уулзахыг дурдах билээ. Сайхан бодвол үнэхээр өөрөө ичмээр ч юм. Гэхдээ яг бодит явдалд тулаад ирэхээр бид чинь яагаад худал хуурмагтаа ичихгүй харин үнэн цагаан болоход ичдэг юм бэ. Би яагаад ийм дорой сурталтай болчихов оо гэж сэтгэл минь үе үе шаналж эхэллээ. Би эцэстээ нөхцөл байдлын тулгалтаар ёстой зориг гаргаж, хувьсгал хийж эргэлт гаргаж байх шиг зориг шулуудан, шүд зуусаар хувцсаа тайллаа.

Миний нүүр гал зулсан мэт халуу асаж, дотор ухаан алдмаар бадайрлаа. Гэнэт аянга нижигнэх мэт дуу гарлаа. Би эхэндээ ухаанаа олсонгүй. Лав л шав шалдан болчихжээ. Ямар муухай юм бэ? гэж элэглэж байгаа гэж бодоод хувцсаа аваад өмнөө барья даа гэтэл хаан эзэн наашаа хараад надтай ав адил шалдан суугаад, ямар ч ичиж зовсон янзгүй их л өөдрөг царайтай, үүлнээс гарсан нар шиг мушийж байв. Түүнийг үзээд миний дотор арай жаахан

уужирч "Шоргоолжны улсын хаан хүртэл ийм байхад би яадаг юм. Өчүүхэн би үхвэл үхэг" гэсэн бодол орж зориг бадрав аа. Тэгээд би толгойгоо өргөх чадалтай болж эргэн тойрныг харахад олон түшмэл мөн л шав шалдан зогсож байв. Миний сэтгэл аажмаар тайвширч тэдний ёсонд дасав. Энэ үед нөгөө аянгын дуу үе үе нижигнэж байв.

Би сонирхож яагаад ийм хэцүү айзам цохилготой аянга нижигнэж байна аа гэж чагнахад, шоргоолжны улсын төрийн түшмэдүүд нь хаантайгаа хамт намайг үнэнч шударга хэмээн баярлаж, ташаагаа ташиж зогсож байжээ. Юуг ташаа ташиж байна гэвэл манай энд зочныг баярлан угтахдаа алга ташдаг бол, харин тэнд ташаан дээрээ баруун гуяны булчингийн гадна талд баруун хөлийн алгаараа пис пис буутал алгадах юм. Би хамгийн түрүүчийн удаа түүнийг харахдаа яг л бөгсөө алгадаж байх шиг санагдсан. Гэвч түүнийг бөгсөө алгадаж байна гэхгүй ташаа ташиж байна гэж хэлдэг юм.



## Долоо. Шоргоолж гүрний засаг төрийн байгууламж

Шоргоолжны хаан миний хариу ёс гүйцэтгэснийг үзээд туйлаас баярлан, олон түшмэдийн ташаа таших нь аянга мэт дууны дунд эрдэнийн суудлаасаа алгуурхан босч, нүцгэнээрээ хувцасны нэрт моделууд зарлан гайхуулж бүхий хувцсаа тал бүрээс нь үзүүлэхийн төлөө 360 хэмээр намбатай сайхан, аажимхан гэгч эргэлдэх шиг яг тийм эргэлтээр миний өмнө олны дунд шалднаар үзүүлэв ээ. Би тэдний заншлын тухай бага сага ойлгосон болохоор түүнийг дуурайж бүтэн нэг эргэлдлээ. Ингэх нь яг алиа хүүхдүүдийн наадам болж байгаа ч гэсэн энэ улсын заншлаар бол харин хариу гүйцэтгэсэн ёс болно. Анх энэ ёслолыг үзэхдээ нүүр халуу шатаад орох газраа олж ядан байсан минь одоо арай гайгүй болжээ.

За бурхан минь хаанд бараалхахдаа юуны өмнө гүйцэтгэдэг гол ёслол нь ийм янзтай бололтой. Энэ бол харийн зочид хаантай уулзаж чухал ажил явдал ярилцах гэхдээ хийдэг уулзалтын ёслол юм. Би шоргоолжны хаантай уулзаад,

- Өчүүхэн миний нэр бол Сул. Зөгийн вант улсын вангийн ордны сонины хорооны сурвалжлагч. Би эрхэм улсад ирж сурвалжлахын сацуу хэрвээ танд ашигтай бол хамгийн амттай хүнс хаана байгааг хэлж өгье гэж ирсэн юм гэж учир явдлаа шууд тоочин хэлсэнд эзэн хаан баярын халуун мушийлт үзүүлэн,

- Би таны ирсэн зорилгын тухай анх манай муруй хөлт жанжны мэдүүлсэн лонхон айлтгалаас мэдсэн юм. Та юу гэв? Хамгийн амтат идээний хаана байгааг хэлэхээр ирлээ гэв үү гэж сонирхон, тамшаалан асуулаа.

-Тэрхүү амтат идээ бол Сүмбэр уулын зүүн суганд байдаг зүү мэт өргөстэй модны намиан дээр ургадаг улаан чавга гэдэг жимс



юм. Тэр жимсний улаан бөмбөг бол чихэрлэг амттай, зажлууртай, тун сайхан идээ. Модны мөчир дамжин үсэрдэг самч гэдэг гайхлууд тун дуртай байдаг юм. Бодвол танай шоргоолжнууд тун дуртай байх биз.

- Манайхан одоо нэг их дайнд бэлтгэж байна. Баруун талын буурцаг харынхан манай идээ үрүү санаархаж байгаа бололтой. Бид идээгээ хамгаалахын төлөө дайсныг устгана. Улаан чавганы аянд мордох их явдлыг хүнсний яаманд даалгана гэхэд нь би амжиж,

- Эрхэм хаантан, та миний өчсөн айлтгалыг тоож хэрэглэхээр болсонд тун их баяртай байна гэж хэлэв. Хаантан миний үгийг инээмсэглэн сонсоод,

- Харин би шоргоолжны улсын өмнөөс танд талархал дэвшүүлмээр байна. Уучлаарай, олон лонх овоорч байгаа нь ямар учиртай болон улсынхаа тойм байдлыг танд танилцуулахыг зөвшөөрнө үү. Манай энэ гүрэн бол тариалан, шавьж сүрэг, хөл /гар ч гэдэг/ үйлдвэр, ан гөрөө зэрэгт түшиглэн амьдардаг. Бид ам бүл олонтой. Манай энэ улсын тоо толгойн нарийн бүртгэл гэж байдаггүй. Манай энэ хааны хот 2000 тойрогтой. Тойрог бүр нь 200 мянган ажилч баатарлаг шоргоолжтой. Үүнээс гадна миний дотоод ордны харьяанд 5000 нүхт орон буй. Орон бүр наян түмэн шоргоолжтой.

Манай улсын дөрвөн том яам, дөрвөн том тулгуур мэт засаг төрөө тулж байдаг юм. Нэгд нь, улсын ерөнхий захирлын их яам, хоёрт нь, дотоод гадаадын аюулаас сэргийлэх энх амгалангийн их яам, гуравт нь, амуу хүнсний их яам, дөрөвт нь, нүх цоолох /бүтээн байгуулалт/ их яам гэж байдаг юм. Их яам бүрт нэг зуу гаруй салбар яам бий гэж танилцууллаа.

Хаан эзний ажил алба тун их байдаг бололтой. Намайг хүлээн авч уулзсан тэрхэн мөчид хэд хэдэн лонхон айлтгал ирлээ. Лонхон айлтгал гэдэг нь олон яамдын түшмэд хаанд ямар нэгэн чухал явдал мэдүүлэхдээ өөрийн биеэрээ очиж чадахгүй үед хэрэглэдэг тусгай айлтгалын хар шавар лонх юм. Хаанд лонхон айлтгал өргөх гэвэл лонхны бяцхан амсарт /яг микрофонд хүмүүс үг хэлдэг шиг/ амаа ойртуулж байгаад хэлэх гэсэн үгээ тод тунгалаг ярьдаг гэнэ. Ярьж дуусмагц хар шавар бөглөөгөөр чангахан дарж бөглөөд хааны ордонд хүргэдэг ажээ. Хар шавар лонх хааны ордонд

хүрч очмогц тусгай хамааралтай лонхон ноёноос хаанд лонх нээх өргөдөл гаргаад зөвшөөрсний дараа лонхоо хааны зарлиг ёсоор нээдэг байжээ.

Лонх нээгдмэгц дотор нь лонхдуулсан айлтгалын үг хоёр хөлтийн дуу хураагчид бичлэг хийсэн шиг тодхон сонсогддог гэнэ. Энэ бол онцгой увдистай лонх юм. Үүнийг хааны ордны ийм онцгой лонх бүтээдэг мэргэжилтэн шоргоолжнууд тусгай шороогоор онцгой аргаар хийдэг гэнэ.

Миний энэ удаагийн хаанд уулзсан ёслол төвөг яршигтай байсан ч жинхэнэ ярилцсан маань хэдхэн хором байлаа. Хэлэх үгээ хэлж дуусмагц цаг болчихлоо. Хаан ямар зочинтой хэдий хугацаанд ярилцах нь тоо хэмжээтэй байдаг ажээ. Энэ үед миний танил дасал болсон хавчгануур түшмэл хажууд ирж,

- За, эрхэм хүндэт Сул гуай хаанд бараалхах цаг дууслаа. Би таныг дагуулж энэ яамны ноёнттой уулзуулъя гэв.

Би түүнийг дагаад улсын ерөнхий захирлын яаманд очихоор явлаа. Нэг их агуйн амсар хүрэхэд зүүн нэгдүгээр хөлөндөө улаан хялганы голоор нь босгож барьсан хамар дороо ганц ганц урт хар сахалтай харуулын хоёр цэрэг уулзлаа. Тэр хоёр харуулын барьсан, улаан хялгана бол тэдний цэргийн зэр зэвсэг гэнэ. Төрийн яамны харуул манаанд улаан шийдэм барьж зогсдог нь тэдний засаг төрөөс тогтоосон ёс журам гэнэ. Улаан шийдмээ хөндлөн барьж зогсвол зочныг оруулахгүй, босгож барьж зогсвол зочин орохыг зөвшөөрсний тэмдэг гэнэ.

Тэдний засаг төрийн хууль, цэргийн цааз маш хатуу аж. Хавчгануур түшмэл намайг дагуулан анхилмал цэцгийн үнэр ханхалсан нэгэн их агуйд орсны дараа дотоод салбарын ордонд хүрэх зүүн талыг барьж явлаа. Би хэсэг гайхаж, цочиж дагжин явсаар сайхан үнэр улам их ханхалж, дууны ая хангинасан их яамны дотоод ордонд орлоо. Энэ бол хавчгануур түшмэлийн хэрэг шийтгэдэг төв ордон байжээ. Энэ нь агуу уужим танхим юм. Хавчгануур ноёны зарц, шивэгчингүүд биднийг үзмэгц нахилзан хөлөө мурийлган ёсолж намайг нэг зөөлөн өвсөн дээр суулгалаа.

Би далавчаа хумисхийн суулаа. Тэр нь тэдний хүндэт зочиндоо бэлтгэсэн тусгай суудал гэнэ. Хавчгануур өөрөө нэгэн хатуу гөлгөр өвсний намиан дээр зургаан хөлөө арзайлган чөлөөтэйхэн суулаа. Ноёнтон надад сурвалжлагын цаг, газрыг зохистой тохируулж өгөх тухай ярилаа. Энэ яамдын харьяанд байдаг ойролцоох газруудаар намайг чөлөөтэй тойруулж үзүүлнэ гэж амлав.

Биднийг ярилцан суух зуур агуйн тэртээ хэрмийн ёроолд гурван эгнээ жагссан шоргоолжнууд шамдуу ажиллаж байгаа нь харагдлаа. Тэдний жагсаалын байдлыг харахад сүүг нь саахаар хоёр мөрлүүлэн зогсоосон хоньд шиг бөгөөд агуйн ордны тэр талаас нь өнөөх гурван мөр жагсаал их л аажим цохилготой, сар сар маажин, түс түс мөргөж, шал шал долоосоор нэгэн хэмээр жигд урагшилж байлаа. Энэ тухай хавчгануур түшмэлээс асуухад ажилч, үйлчлэгч шоргоолж буюу боол зарц нар ордны дотоод цэвэрлэгээ хийж байгаа нь тэр юмсанжээ.

Нэгдүгээр эгнээнд нь арсайсан, барсайсан, доройсон газрыг тэгш болгохоор сар сар маажиж, хоёрдугаар эгнээнд нь хэрэм, шалыг гөлгөр хатуу, бөх сайхан болгохын төлөө духаараа түс түс мөргөж толгойдон (лантуутан) гуравдугаар эгнээ нь бас нэг утсаар холбогдсон мэт шатсан хэрэм, шалыг гөлгөр хатуу бөх сайхан болгохын төлөө шал шал долоон, шүлсээрээ цавуудан цардаж байгаа нь энэ аж. Би гайхан нэгэн ажилч шоргоолж түр амсхийх хооронд,

- Та ядарч байна уу гэж асуулаа. Гэтэл тэр шоргоолж нөхөрсөг, хөнгөмсгөөр надад хандахдаа үнэнч шударга царайгаар,

- Мэдэхгүй гэв. Би маш их гайхан хажууд байсан хавчгануур гуайгаас дээрх асуултаа давтан асуухад үгийн утгыг ойлголгүй,

- Та түүнээс чухам юу байна уу гэж асуув аа хэмээн гайхлаа.

- Танай энд залхуу бий юу?

- Ховор оо ховор. Бид өглөөний цайндаа тэмээлзгэний шийр, дэвхрэгний гуя хөшиглөж уудаг. Идье гэхнээ залхуу олдохгүй гэхэд нь би улам гайхаж инээд хүрээд яахаа олохгүй болов. Хавчгануур

миний арай ядсан байдлыг хараад ажилчны асуултыг тодорхойлон тайлбарлах санаатай,

- Тэр идээ манай энд гардаг эд биш. Гадаадаас оруулдаг. Тиймдээ ч тун ховор. Эзэн хаан өглөөний цайндаа хийж уудаг байх гэж миний үгийг огтхон ч ойлгоогүй хэр нь ажигч үгүй мэдэмхийрэн хэлэв.

Учир нь шоргоолжны улсад ядарна, залхуурна гэдэг үг язгуураасаа байдаггүй гэнэ. Тэдний хэлж байгаа залхуу бол нэгэн зүйл идээний нэр гэнэ. Маш ховор олддог эрэгчин шавьжны бөөрийг залхуу гэдэг гэнэ.

## Найм. Шоргоолжны дээд давхаргын ордон харш, ажилчдын орон сууц

Би хүндэт хайрт хавчгануурын дагуулаар Шоргоолжны хаант улсын төрийн байгуулалтыг тойм төдий ойлгов. Дараа нь бүтээн байгуулалтын их яамны хамгийн бүдүүн толгойтой уулзлаа.


Энэ ноёнтон дөрвөлжин толгойтой урт урт зургаан нарийн хөлтэй, богинохон сахалтай даруу зантай шоргоолж байв. Хавчгануур гуай намайг түүнд тушааж,

- Сул гуайн хүсэлтийг биелүүлээрэй гэж буцаж явлаа.

Дөрвөлжин толгойт ноёнтон сайд нарын зөвлөлийн ордны тойргийн харшид суудаг байжээ. Тэр намайг дагуулаад өргөн, нарийн, гүдгэр, хотгор, харанхуй, саруул, муруй саруй замаар яваад л байлаа. Би бол тэнгэр дээгүүр нисдэг шавьж болохоор түүнийг дагаж агуй дотор явах нь тун төвөгтэй, байн байн хоцорч явлаа. Эхэндээ надтай зэрэгцэж явахын тулд нарийн нуруун дээрээ биенээсээ хэд дахин том чулуу авч тавиад усан зураг гүйдлээр жирэлзэн гүйлээ. Гэвч би бас л түүнийг дагаж гүйцэхгүй байв. Тэр гэнэт нэг сайн арга олсон шиг,

- Тэнгэрийн хүндэт зочин минь би ингэж чулуу үүрч хурдаа сааруулж явахын оронд таныг шууд үүрээд гүйвэл хурдан мөртлөө таны биед амар биш үү гэв. Түүний саналыг сонсоод миний дотор эвгүйцэн,

- Би таниар үүрүүлээд явна гэдэг ичгэвтэр хэрэг биш үү гэж цааргалав. Түүний толгой нь дөрвөлжин, харц нь маш ихэмсэг дүртэй боловч ямбагүй, төв шударга, ёсорхог сайн шоргоолж ажээ.



"Бид газар дээгүүр явахдаа та нараас хурдан, хүнд юм өргөхдөө та нараас хүчтэй байх нь мэдээж. Гэвч тэнгэрээр нисвэл та нар хол хурдан биш үү. Энэ чинь хувь хувийн онцлог давуу тал юм. Бид хамтран ажиллана гэдэг чинь бие биеийн дутагдлыг нөхвөрлөж, хамтаараа элбэг дэлбэг хүнс цуглуулан сайн сайхан болохын төлөө биш үү" гэж хэллээ.



Гэтэл би яаж ч бодсон Шоргоолжны хаант улсын төрийн дөрвөн тулгуурын нэг болох том сайдаар үүрүүлнэ гэдгээ сонсмогц хамаг биеийн үс арзайж, айдас хүрэх мэт болно. Дөрвөлжин толгойт ноёнтон миний нэрэлхэж байгааг мэдээд,

- Та эрээлэх хэрэггүй. Миний нуруун дээр хурдан морд. Би танай тэнд очвол та нарт харин их дараас нэмж мэднэ шүү. Алс холын аян замын уул ус бэрх бартааг алхаж туулна гэж санахын хэрэггүй. Харин та намайг үүрээд нисвэл яадаг бол...

- Тэгэхээр та манай энд ирсэн нь хувь учиртай, би таныг үүрэх түм түмэн оны шоргоолжны түүхэнд анх тохиолдож байгаа ийм ховор нандин завшааныг яахин хялбараар алдаж болно гэж хэлэв.

Яаж ч нэрэлхэж маргавч тусгүй тул би эцэст нь арга буюу түүний нуруун дээр гарч найдлаад давхианд нь хаягдахаас хичээж тасархай нарийн бэлхүүсээр нь дангинатал тэврээд суулаа.

- Би хүний ертөнцийн хүүхдүүд илжиг унаад жороолуулж явахыг үзсэн боловч өөрөө ямар ч унаа унаж үзсэнгүй. Тэр тусмаа шоргоолж унана гэж ёстой зүүдэлсэн ч үгүй. Эхэндээ миний дотор айдас хүрч байсан боловч нэг хэсэг явсны дараа сэтгэл уужирч тайвширлаа.

Манай аялал үргэлжилсээр байлаа. Тэгшхэн замаар жирэлзүүлж хальтралгүй, харанхуй замаар төөрөлгүй, сайхан замаар сайварлан явлаа. Уул тал, голыг өнгөрөн явсаар нэг мэдэхэд нэгэн гял цал буусан агуйд орж явсаар огцом эргэж нэгэн саруулхан уужим агуйд орж ирсэн чинь дөрвөлжин толгойт ноёны суудаг ордон харш байжээ.

Агуйн үүдэн дээр нэгэн хар шоргоолж хэрэн зогсож байсан нь үүдний харуул байв. Дотогш орвол ногоон өнгийн гялгар шалтай, шалан дээрээ улаан, хар, цагаан гээд өнгө өнгийн өвс модны нимгэн дүрсийг хивс болгон дэвсчээ. Шар өнгийн ханатай уужим агуйн буланд гурван хэсэг өөхөн чулууг зэрэгцүүлж тавьжээ.

Тэр нь дөрвөлжин толгойт ноёнтын ажил хэрэг явуулахдаа

сууж зарлиг буулгадаг, уур хүрэхдээ алгаддаг ширээ нь байжээ. Ширээний хажуугаар өвсний бүдүүн бүдүүн үндсүүд байсан нь тэдний сандал гэнэ. Энэ ноёнтын сууц нь унтах гэр, хоолны өрөө, зочны өрөө, хүнсний хөмрөг гээд дөрвөн хэсгээс бүрэлддэг ажээ.

Би сайдын ордноос гараад ажилчдын сууцыг ажиглаж явлаа. Тэдний сууц хэдийгээр дөхөм хялбар бүтэцтэй, эдлэл хэрэгсэл нь бүдүүлэг барзгар, цөөн боловч өөрийн савраараа нэг нэг ширхгээр барьж, хумсаараа нэг нэг зураасаар сийлж, шүдээрээ ширхэг алдалгүй мэрг, урлаж байгуулсан ажээ. Би тэдний гэртээ унтаж байхыг үүдээр нь харахад олон зуун хөлнүүд нь арзалзан хар хөвөн зулсан мэт харагдаж байлаа.

Том том агуйн уудам хөндийгөөр ажилчид амьдарч суурьшдаг байжээ. Тэдэнд газар нь дэвсгэр, агуйн дээвэр нь хөнжил, жигд гозгор чулуу нь дэр болдог байна. Хөлдөө гуталгүй, толгойдоо малгайгүй тун ч эгэл боргил амьдардаг ажээ.

## **Ес. Шоргоолж ажилчдын хөдөлмөрлөж байгаа байдал**

Би тэдний заншлыг овоо ойлгож дассан болохоор жаахан чөлөөтэй явъя гэж санаад дөрвөлжин толгойт ноёнд,

- Та өөрийн ажил албандаа яардгаараа яар даа. Надад нэг зам дагуулагч өгвөл болчихно гэж гуйлаа. Тэр миний гуйлтыг хүлээн авч нэг залуу ажилчин дуудан авчирч надтай уулзууллаа. Ордноос гараад жаахан явж тун олон ажилчин шоргоолжны нааш цааш зөрөлдөн, өргөн уудам хөдөлмөрийн талбайд ажиллаж байхыг нүдээр үзлээ.

Тэр эмх цэгцтэй хөдөлмөрийн сайхан уур амьсгалтай золгомогц миний дотор уужран, хөгжиж догдлох янзтай боллоо. Би тэдний урам баяртай, идэвхтэй хөдөлмөрлөж байгааг бахархан харсаар хэдий хол явснаа ч мэдсэнгүй. Нэг мэдэхнээ нэгэн шинэ уран гоё сийлбэртэй ордны гадаа нэг аварга том цагаан чулуун гуурс (хожим нь би саяын цагаан гантиг чулуу биш, харин аварга гүрвэлийн дунд чөмөгний яс гэж мэдсэн юм)-ыг мэргэж байхыг үзсэн.

Тэр дунд чөмөгний ясаар хааны ордны тулгуур хийдэг гэнэ. Тийм аварга ясыг 999900 шоргоолж 888800 өдөр зогсолтгүй мэрдэг гэнэ. Нэг дунд чөмөгний ясаар 777700 тулгуур хийдэг гэнэ. Нэг тулгуурыг туйлын уран нарийн сийлбэр оруулан гайхамшигтай гоё сайхан юм болгон босгоход 99000 шоргоолж үүдэн шүдээ элээж насны амралтаа авч, тэтгэвэрт гардаг ажээ.

Нэг их ордон харшийг байгуулж дуусахад есөн үеийн найман аймгийн шоргоолж шөрмөсөө сунгаж, шүдээ барж амь насаа үрэгдүүлдэг байжээ.

Тэд нэг ордныг байгуулахад тоо тоомшгүй зөөврийн анги зохион байгуулж, алс холоос өвс, хулс, яс, мод, чулуу мэт барилгын



материал авчирдаг байна. Хэдий хүнд юмыг халшралгүй үүрч чирч түлхэж бөмбөрүүлсээр авчирдаг гэнэ. Тэд бол дэлхийн бөмбөрцгийн хамгийн гарамгай хүндийг өргөгч байжээ. Жаахан биеэсээ долоон зуу дахин хүндийг өргөдөг байна.

## Арав. Шоргоолжны мал, тариалан

Би тэндээсээ гараад зам дагуулагчтай хоёулаа явж байтал нэгэн их нов ногоон хүрээлэнд орлоо. Тэгсэн чинь тэр нь шоргоолжны тариалангийн талбай байлаа. Нэгэн их тариалангийн атаршуулсан газар хэдэн зуун шоргоолж хоёр урт мөрөөр хөндлөн жагсаад бидний өөдөөс тоос манаруулан урагшилж байлаа. Тэд хоёрхон хөлөөрөө явж байсан нь миний гайхлыг төрүүлэв.

Нөгөө дөрвөн хөл нь хаачдаг байна. Тэгээд тэднийг нэлээд ойртоод ирэх үед нь сайн ажиглавал газар хагалж байгаа нь тэр юмсанжээ. Энэ хөндлөн урт жагсаалд оролцсон шоргоолж бүхэн арын дөрвөн хөлөө газарт шигтгээд анжис шиг газар хагалж, урд хоёр хөлөөрөө газар дээгүүр алхаж, урагш хүчлэн “анжсаа” чирч байлаа. Энэ жагсаалын араас дагаад хөндлөн урагшилж байгаа хоёрдугаар мөрийн эмэгтэй тариачин шоргоолжны жагсаал үр цацаж байлаа.

Тэдгээр тариачин шоргоолж нэг мөхлөг үр цацах бүрдээ нуруунаасаа нэг дусал хөлс бөмбөрүүлэн унагаж тарианы үртэй хамт газарт булж байлаа. Шоргоолжны биенээс хөлс гараад дусалж байх нь ер харагддаггүй билээ. Тэгсэн чинь тэр нь тариа тарих үедээ хөлсөө шавхаад хөрсөн доор тарианы үртэй хамт булчихдаг байж л дээ. Тэд залхуурах, ядрахыг мэдэхгүй гагцхүү ажиллахыг л мэддэг байгал ертөнцөд хосгүй өвөрмөц заншилтай юм. Би тэдний тариаланг хараад,

- Танайхан бас мал малладаг юм уу гэж асуухад, зам дагуулагч:

- Тийм, тийм. Танд үзүүлье гэв. Би түүнийг дагаж тэдний малын талбайг тойрч үзэхээр явлаа. Өвс бэлчээр сайхан ургасан хөдөө талаар явсаар нэгэн их асга хадтай энгэр ойртоход зам дагуулагч маань чулуун хашааг зааж,

- Ээ, энэ чинь манай малын талбай гэв. Би баярлан хашаанд ойртож хүрээд өнгийж харвал олон гуйлгачин хорхой арзайн харагдахад хачирхан,

- Энэ чинь мал юм уу? Гуйлгачин хорхой л байна шүү дээ. Энэ малыг тэжээгээд арьс, шир, үс ноолуурыг нь авдаг уу, шөл уудаг уу, сүүгий нь саадаг уу гэж асуухад,

- Үгүй ээ, хүйсийг нь л долоодог юм гэв. Би бас л гайхлаа. Хоёр хөлтнүүд үхэр, хонь, адуу, тэмээ, ямаа тэжээгээд махыг нь идэхээс гадна дэлэнгий нь шувтраад сүүгий нь сааж уудаг шүү дээ. Гэтэл шоргоолж, гуйлгачин гэдэг шавьжийг арчлан тэжээгээд хүйснээс нь шүүрэн гардаг нэгэн зүйлийн исгэлэн амттай шүүсийг нь сорж долоодог байжээ. Энэ үнэхээр инээдэмтэй.

Би шоргоолж улсад ирээд амаа ангайдаг, дуу алддаг, гуяа алгачихдаг нэгэн зүйл гайхдаг "өвчин" олчихлоо.

## Арван нэг. Шоргоолжны хүүхдийн цэцэрлэг

Мал тариалангийн талбайгаас гараад шууд хүүхдийн цэцэрлэг үрүү явлаа. Би тэгж явах замдаа шоргоолжны хүүхдийн цэцэрлэг ямар байдаг бол, арвин зүйлийн наадам өрцгөөсөн олон мянган хүүхдүүд тоглож байгаа байдал нүдэнд харагдах биз ээ.

Тэд чухам бичиг үсэг, тоо мэддэг болов уу гэж бодож байв. Тэгээд тийм ч их удсангүй шоргоолжны хүүхдийн цэцэрлэгт хүрлээ. Манай зөгийн хүүхдийн цэцэрлэгийг бодвол тэднийх нэн том талбайтай, газрын гүнд байгуулсан агуй байлаа. Агуйд сая л өндөгнөөсөө сугарч гараад тэнтэр тунтар алхаж байгаа жижиг зулзганууд арзганаж байлаа.

Бид хоёр шоргоолжны хүүхдийн цэцэрлэгт ойртож очоод үзье гэж байтал гэнэт мод, өвсөн том овоо агуйн цаад өнцгийг ороогоод гарч ирлээ. Би гайхан ажиглаж, анх энэ улсад орж ирэхэд тохиолдсон улаан шороон суваргын нүүдэл санаанд оров.

Тэгээд том түлээн овоон доогуур нарийвчлан хартал бас л өнөөх уул нүүлгэдэг ажилчин шоргоолжнууд идэрхэг зургаан хөлөө эмх дараатай зөөн урагшилж аварга том түлээн овоог нүүлгэж байлаа. Тэгтэл асрагч шоргоолжнууд тэр овооны мод өвснөөс зулзага бүрт нэг нэгийг авч бариулав. Би бас л хатуу оньсого тулгарсан мэт гайхам чухам ямар учиртай болохоор эдгээр зулзагануудад өвс, мод атгуулж байна аа гэж гэж өнөөх залуугаас асуулаа .

- Эрдэм мэргэжлийг зулзаганаас нь сурга. Эмнэг гуйлгачин (хүйснээс нь амтат шүүс шүүрүүлдэг хорхойн нэр)-г эртнээс долоо гэсэн манай шоргоолжны мэргэн үг байдаг. Манай энд хүүхдүүдийг мэндэлмэгц энэ мэргэжил эрдэмд дасгаж сургадаг, цэцэрлэгт орсон хүүхдүүдээ юуны өмнө шийдэм бариулж анхны наадам (хялбар хөдөлмөр) хийдэг гэнэ.



Тэд мод, өвс чирэхийг сурна, үүрч зүтгэхийг сурна, хэмлэж мэрэхийг сурна. Энэ мэт бага багаар наадаж сурсаар өсч хүмүүжин том наадамчин (хөдөлмөрчин) болно гэж дагуулагч надад тун тодорхой тайлбарлаж өглөө.



## Арван хоёр. Тэдний хачин сонин тоглоом

Сул би сонирхлын ертөнцөд орж ирээд цочиж гайхах, баярлаж хөгжихийн алинд ч завдахгүй зүг зүгт татагдан ийш тийш ангалзан харж явтал шоргоолж анианууд зулзагануудыг цэргийн сургууль хийлгэж байгаа шиг тун аймшигтай сонин тоглоомоор тоглуулж байх нь харагдав. Нэг сүрэг зулзаган шоргоолжийг асга хадаар унаж тустал нь авируулан нөгөө талаас нь олон шоргоолж нум сумаар харвана. Сумнаас нь зайлж гарсан зулзаган шоргоолжнууд нэгэн том уутанд орж түр нуугдсанаа дахиад ажилчин шоргоолжны будаа нүдэж байгаа ууран дотор орчихлоо. Миний бие зарсхийлээ. Түүрүүчийн гайхаш барагдаагүй байтал цэцэрлэгийн хүүхдүүд дунд мушгирсан урт сахалтай жижигхэн өвгөн байсан нь бүүр ч сонин санагдав. Тэгээд нөгөө замчаасаа учрыг асуухад,

- Хүндэт, Сул гуай минь. Цаадах сайхан сахалт чинь өвгөн шоргоолж биш, балчир бяцхан хүүхэд шүү.

- Ээ, энэ чинь тэгээд нялхаараа сахалтай болчихсон юм уу?

- Тийм ээ, манай шоргоолж удмынхан эхээс төрөхдөө сахалтай төрдөг юм гэв. Би улам сонирхож сайхан сахалт бяцхан шоргоолжтой ярилцаж үзвэл хий насаараа зуун настай байлаа.

- Жаал чи, хэдийгээр урт сахалтай боловч балчир нялхаараа юм байна шүү дээ гэвэл, тэр:

- Тийм ээ, би бол өчигдөр өндөг, өнөөдөр зулзага, маргааш баатар гэж хэллээ. Би түүний хариулсныг сонсоод, бас түүрүүчийн гэнэн, аймшигтай сонин тоглоомыг санаад,

"Уухай туухай баатар

Ууцан дундуураа тасархай баатар

Уутанд хийвч баригддаггүй баатар



Ууранд хийвч нүдэгддэггүй баатар

Хаданд халтирдаггүй баатар

Харвах суманд оногддоггүй баатар” гэдэг оньсого чинь эдний багаас нь зориг зүрхтэй, мэргэжилдээ боловсорч сурдгийг үзээд зохиосон юм байна гэж мэдэв. Тэд биеэ дааж амьдрах чадвар, мэргэжлийг нүүрээ угаахаас эхлээд бага багаар эзэмшиж сурдаг юм.

Бид хажуунаас нь харахад өмнө хоёр гараараа нүүрээ үрж илэн, хүн гэдэг хоёр хөлт гозгоруудын “амьсгал тамирын” дасгал хийж байх шиг аашилна. Энэ нь хүн шиг усаар, муур шиг шүлсээрээ угаах биш, харин агаараар угаадаг гэнэ. Тэд түүнээ “тэнгэрээр нүүрээ угаана” гэж сүр бадруулан ярьдаг ажээ.

## **Арван гурав. Тэдний цав манзны хачин сониныг хэлвэл шал инээдэм**

Бид тэдний багаасаа хатуужилтай, орчин тойронд биеэ хамгаалахыг нарийн хичээнгүй сурч боловсрон, эрдэм мэдлэг эзэмшин байгааг гайхан харж явтал, гэнэт навчин шүгэл дуугарлаа. Шүгэлдсэн газар уруу сэртэлзэн харвал хоёр хоёроороо хосолсон хэдэн арван шоргоолж хорь хориор багцалсан шар шумуулын бүхэл бие хатаамал борцнуудыг дамнаж авчраад, том хавтгай чулуун тэвшин дээгүүр зайтай зайтай мөрлүүлэн тавилаа.

Тэгээд би тэднийг цав манз барих гэж байгааг мэдлээ. Дараа нь бүхэл шумуул бүрийн хажууд тус бүр нэгэн мөхлөг шарангуй ногоон өнгөтэй жижиг ногоо, бас хажуу нь нэгэн ширхэг үс мэт нарийн цагаан гуурс тавилаа. Би түүнийг нь хатгаж идэхэд хэрэглэдэг савх юм гэж таамаглав.

Энэ нь тэдний цав барих бэлтгэл гэнэ. Би олон цэцэрлэгээр явж хүүхдүүдийн хоол идэж байхыг үзсэн ч ийм сонин идээ зууштай цавыг анх удаа үзэв. Намайг гайхан мэлэрч байх хооронд хүүхэд шоргоолжнууд аль хэдийн суудал суудалдаа томбойн сууцгаажээ. Тэгтэл өнөөх навчин шүгэлт ноён шүглээ сүр баясгалантай үлээгээд,

- Хүүхдүүд ээ, Шоргоолжны хаант улсын эрүүл энхийн төлөө одооноос "шал шал" гэв. "Шал шал" гэдэг нь "идэцгээ" гэсэн хүндэтгэл утгатай үг гэдгийг би сонсмогцоо мэдэв. Тэд тэр шумуулыг хоншоороос нь эхэлж идээд дараа нь далавчийг нь харчигнатал зажлан залгиж байв. Тэдний идэх нь хүртэл ёс дүрэмтэй гэнэ. "Үзүүрээс нь үмхэж, ухаас нь залгилна" гэдэг үг хүртэл байдаг гэнэ.



Шумуул ногоон мөхлөг (амуу) бүрийг зооглосны дараа олон шоргоолж дамжлан асар том тарган голио оруулж ирэв. Түүнийг саяхан халгайн дундаас агнаж ирсэн болохоор шүлс гоожмоор үлээсэн бөмбөг шиг цүлхэлзсэн бүдүүн гэдсийг харахад тосоор дүүрэн байгаа нь нэвт үзэгдэж байлаа.

Ийм хоёр ч голио авчраад тэвшин дээр тавьж "манз бариарай" гэж хэлтэл хүүхдүүд бүхэл голиог тойрон зогсоод өнөөх цагаан соруулаараа тал талаас нь гэдэс рүү нь хатган соров. Миний инээд хүрч тэсгэл алдахдаа гуяа чимхэж зогслоо.

-Шумуул гэдэг чинь хүн амьтны цусаар амьдардаг нисэгч тээрэм. Шим тэжээл нь бугын цусан эвэртэй адил гэж мэд. Бас тэр ногоон мөхлөгийг бага гэж битгий бод. Тэр чинь хүний иддэг орхоодойгоос тавин нэг дахин илүү шим тэжээлтэй эд шүү. Голио гэдэг чинь ногооны хамгийн охь, шим шүүс тосоор нь гэдсээ бөмбийлгөсөн, манай шоргоолж улсынхны амьдаар нь гүзээлсэн эрдэнийн ногоон тос юм гэж замч маань тайлбарлаж байлаа.

## Арван дөрөв. Шоргоолж охидын гоо үзэсгэлэнгийн уралдаан

Замч бид хоёр тэндээс гараад нэгэн тосгоныг чиглээд явж байтал олон ажилчдын тэг дөрвөлжин жагсаалын өмнө алтан хялганаар арал хийсэн ижил найман гоёмсог сүйх тэрэг явж харагдав. Гоёмсог чимэглэлтэй ордныг зорьж яваа энэ цувааны сүйх болгон дээр Шоргоолжны хаант улсад ховорхон харагдсан гоо охидыг нэг нэгээр суулгаж янз янзын цэцэг навчаар гоёод өнгө өнгийн чулуу, шороо, ургамлын будгаар хөлийн хумснаас эхлээд хөмсөг, сахал, эвэр дээрээ хүртэл буджээ. Замчаас учрыг асуувал “Үзэсгэлэнт хүүхний шалгаруулалтад орохоор явж байгаа нь энэ” гэв. Бид хоёр тэнд ороход уянгалаг хөгжмийн ая дуурсаж, гоо охидын үзэсгэлэн шалгаруулалт эхлэх гэж байгааг зарлалаа.

Юуны өмнө энэ удаагийн гоо үзэсгэлэн шалгаруулах болзол, шалгаруулалтын комиссын нэрсийг талбай дээр ил тод тавилаа. Түүнийг сонирхвол нэгд, нурууны нарийн нь хааны нарийн сахлаас нарийн байх хэрэгтэй. Хоёрт, аль ч хөлийн нарийн нь хааны хамгийн бүдүүн сахлаас бүдүүн байж болохгүй. Гуравт, нүд нь хааны наймдугаар хатны нүднээс том байх, эвэр нь заавал биеийн уртаас хоёр дахин урт байх хэрэгтэй. Дөрөвт, хэдийгээр интоорын уруултай байхыг шаардахгүй боловч уруулын сэтэрхий нь ил тод байх хэрэгтэй. Тавд, сахалгүй байж үл болно. Гэхдээ заавал ямааны ноолуураас зөөлөн байх хэрэгтэй. Зургаад, хөл дээрээ заавал нэг урт үстэй байх хэрэгтэй. Тэр бол шоргоолжны шилбэний чимэг. Долоод, гэдэсний нь хэмжээ нь хааны гэдэсний цүлхгэрийн тавны нэгээс давж болохгүй. Хөөрхөн жижиг бөмбөгөр лонх шиг л байх хэрэгтэй. Наймд, зургаа болон ганц хөлийн бүжигт чадамгай байх, жирхрэн дуулах, шуухитнан дуулдаг байх хэрэгтэй.



Зарлагч үүнийг нэг нэгээр нь уншиж дуусмагц алга ташлаа. Зарим нь бүр ташаа ташин халуунаар хүрээлж байгаагаа илэрхийллээ. Шалгаруулалтын комиссын гишүүд тусгай засан суудалдаа сууцгааж гоо сайхан охид найм наймаараа тайзан дээгүүр эмх журамтай мурилзан алхаж, төв зогсон тодорхой



үзүүлэх, шоргоолжны төрийн арзагануур бүжгийн үндсэн хөдөлгөөнийг биелж үзүүлэх, шоргоолж ятга чавхдан хөгжимдөж, дуулах мэтээр тогтсон хөдөлгөөнийг шалгаруулалтын шаардлага ёсоор гүйцэтгэж байлаа. Энэ мэтээр найм наймаараа хэдэн зуу дахин үзүүлбэр хийгээд гоо сайхны шалгаруулалт өндөрлөлөө.

## Арван тав. Тэдний хуримын ёслол


Би шугуйд ороод өвс мод, ургамал, цэцэг навчаар өвч бүрхэгдсэн байгалийн цэцэрлэг дундуур сүлжин явж байтал гэнэт миний хажууд ёолох дуу гарлаа. Миний айж цочсон гэж. Лавлаж харвал миний хөлийн хажууд шоргоолжны шилбэний нэгэн ширхэг урт хар үс харагдлаа. Цааш лавлавал шинэ бэрд л байдаг тиймэрхүү гоц сайхан нарийхан шилбэ харагдлаа.

За, тэгтэл мунхаг толгой чинь шинэ бэрийн ганган гоё будмал хумстай хөөрхөн булбарай тавдугаар хөлийг нь гишгэчихсэн байв. Би буруугаа мэдэж уучлал гуйлаа. Тэгээд учир явдлыг замчаасаа асуувал,

- Би таны хүслийг биелүүлэхээр танд хэлэлгүй нийтийн хуримын ёслолын талбайд дагуулж ирсэн юм. Энэ агуу уудам шугуйн хөндий бол хуримын ёслолын талбай. Одоогийн энэ завсар зайгүй эгнэн бүжиглэж байгаа чинь цэцэг навчсын өвч чимэглэлтэй шинэ бэр, шинэ хүргэний ой хөвчийг бүрхсэн их жагсаал юм гэж хэлэхэд нь заасан зүг үрүү харвал үнэхээр ой шугуйн нэгэн хэсэг чөлөөнд өнгө өнгийн цэцгэн орхимж нөмөрсөн үй олон хос шоргоолж залуус жагсаалаараа дуулан, бүжиглэж байв.

Замч залуугийн хэлснээр Шоргоолжны хаант улсын залуучууд миний мэддэг тоосноос хол, арвин их байдаг болохоор арван мянга арван мянгаар сүрэглэн ангилж хуримын ёслол явуулдаг гэнэ. Ингэж байтал, нэгэн өндөрлөг дээрээс хуримын ёслолыг эрхэлж байгаа ерөнхий захирагч,

-Одоо хуримын ёслол эхэллээ гэж даян дэлхийд үхэр бүрээ шиг хүнгэнэсэн бүдүүн хоолойгоор зарлахад сүр бадрангуй цог жавхлантай найрал хөгжмийн ая дуурсан, дараа нь хуримын захирагч хуримлагч залуусаас амлалт асуухад тэд нийтээрээ



товчхон хариулав. Захирагч,

- Та нар бие биедээ голоосоо хайртай юу гэхэд олон залуус  
нэгэн дугаар,

- Голоосоо хайртай гэж ой тайгад цуурайттал хариу хашгирав.

- Та нар хонио хариулахдаа хоёулаа бол...?
- Тийм. Ходоодоо идэхдээ ч хоёулаа.
- Хань нөхөр чинь ойчвол яах вэ?
- Зургаан хөл (гар)-өөрөө тэвэрч босгоно.
- Хань нөхөрт чинь таны аврал хэрэгтэй бол яах вэ?
- Толгойгоо өгөхөд ч бэлхэн.
- Та хоёр юунд шүтэж амьдарна вэ?
- Наадам (хөдөлмөр)-д.
- Та хоёрын хамтын хүсэл юу вэ?
- Хүүхэд.

Энэ мэтээр захирагч ноён олон асуулт асуухад тэд ганц хоёрхон үгээр хариулав. Дараа нь бэлэг солилцох болоход өвөр өврөө тэмтрэн бие биедээ бөөрөнхий боржин чулуу бэлэглэв. Энэ нь янаг дурлалдаа чулуу шиг бат хатуу байж, сэтгэл хувирахгүй гэсэн бэлгэдэл ажээ. Хуримын ёслол өндөрлөхөд шинэ хүргэнүүд өөр өөрийн эхнэрээ үүрээд жаргалын ордон уруу явцгаалаа.

## Арван зургаа. Тэдний шөл ууж байхыг хараад элгээ хөштөл инээв

Замч бид хоёр явж байтал нэгэн том уул уначихсан байх шиг тэнгэрт тулам тоос босох нь харагдлаа. Би гэж хэрэгт дуртай толгой юм чинь тэр зүгт дэлдэгнэн тэмүүлэв. Тэнд тулж очоод үзсэн чинь маш олон шоргоолж байлдагчид нэгэн аварга том азарган царцаахайг дарж унагаад шөл уухаар тэлчлүүлж байв. Тэр царцаахайн бүдүүнийг дүрслэхийн аргагүй. Олон зуун шоргоолж аварга царцаахайтай агаарын нарыг хирттэл байлдаж, өвсөн дундуур өнхрөлдөн тулалдаж, өргөст халгайг өөрийн болтол зодолдон тэмцэлдээд хамтын хүчээр дарж явлаа.

Олон зуун шоргоолж уулан дээр гүйлдэх мэт царцаахайн биен дээгүүр цааш нааш сүлжилдэн гүйхдээ тун их баярлалдан, зарим нь исгэрч дуулсан шиг, зарим нь бөгсөө алгалан бүжиглэсэн шиг, баяр дурсгалтай өдрийн уур амьсгал бялхаж байлаа. Бид хоёр өнөөх "уул"-ын цаад талд гараад хамгаас хөгжөөнтэй ажиллаж байгаа шоргоолжны чуулгыг харвал бөөрөнхий довцог мэт царцаахайн гэдэснээс гуурсаар тос гоожуулан, ногоон буурцагны навчин урт онгоцонд юүлэн авч байв.

Нөгөө талд нь тосоор дүүргэж тавьсан навч нь онгоцны хоёр талаас яг ундаассан адуун сүрэг ус ууж байх мэт залгилан, ууж ханасан шоргоолжнууд уруулаа долоосоор явцгааж байлаа. Тэгж байтал нэгэн хүүхэд шоргоолж царцаахайн тосонд гэдэс нь аль эрт дүүрээд, тос амаар нь гарах дөхсөн ч нэгэн амьсгаагаар залгилсаар л байлаа.

Хэрэв хажууд нь байсан өвгөн шоргоолж хэлж өгөөгүй бол тэр гурван шөнө, гурван өдөр залгилж ч мэдэх байлаа. Би түүнийг үзээд ёстой нэг элгээ хөштөл инээлээ. Тосонд ханасан шоргоолжнууд хүч тамир ормогцоо дахин нөгөө уул мэт царцаахайн биен дээр мацаж гараад ангийн олзоо хөмрөгтөө оруулах ажил хийж эхлэв. Хүч



тамираа ихээр сэлбэсэн шоргоолжнууд “дөрвөн мөчийн дугуйлан”, “гэдэс ходоодны дугуйлан”, “толгой, хүзүү, сахлын дугуйлан”, “далавч, нурууны дугуйлан” гэсэн дөрвөн том бүлэгт хуваагдан ажиллав. Том царцаахайг мөч мөчөөр нь, эрүү багалзуураар нь, гэдэс дотроор нь, таван цулаар нь хэсэглэн салгаад хэд хэдээрээ өргөж дамнан хөмрөгтөө яаралтай орууллаа.

Би тэдний гал халуун хөдөлмөрийн урам бах, тэнгэрт тулам эр зориг, орчлон дэлхийд хосгүй гайхалтай хүч чадал, ажилдаа чанга нямбай хариуцлагатай ханддагийг олж мэдлээ. Эд нар бол туйлын гарамгай, хүчтэй ав хоморгын цэрэг анги гэнэ. Тэд өдөр бүр халдаж ирсэн дайсныг устгаж эх нутгаа хамгаалахын зэрэгцээ бүх улсын хүнс хүчийг бэлтгэх үүрэгтэй гэнэ. Тэдний хамгийн гол дайсан нь нүгэлт царцаахай байжээ. Учир нь царцаахай тэдний төмс тариа, тэжээвэр хорхой (мал)-г цөлмөж идээд гай гамшиг учруулдаг төдийгүй ургамал, шороо, чулууг нь хүртэл залгидаг дээрэнгүй мангас гэнэ.

## Арван долоо. Тэд хар голын байлдаанд хүнд гарз хохирол амсав

Би сурвалжлагчийн ажлаар ертөнц бартал тойрсон ч халуун тогоонд орсон шоргоолж гэгч чухам ямар байдгийг анх удаа нүдээр үзлээ. Хуучин танил өвгөн жанжны бүх бие дагжин чичирч туйлын өрөвдөлтэй харагдлаа. Шоргоолжны хаант улсад хэрвээ амьтай чацуу том асуудал, аймшигтай хэрэг гарвал тэрхүү ажил явдлыг хамаарсан ноёнтон нь аяндаа халуун тогоонд ордог жам хуультай гэнэ.

Халуун тогоонд нэг орчихвол ерөөс гардаггүй, далд хөлсөө асгаруулан үсэрч цамнан, бүжиглэж чадахгүй ч бүжигчин болж, орилж хашгиран, дуулж чадахгүй ч дуучин болж, онгод буулгамаар аашилж байв. Энэ мэт биеийн эрхтэн, эс бүхнээ дайчлан арга шавхаж сайн арга олдог гэнэ. Тиймээс өнөөх жанжин арга буюу хуурай халуун тогоонд ордог ажээ.

“Эдэнд чухам ямар аюул тулгарав аа” гэвэл мөн өдөр царцаахай агнаж шөл уусан учир бусад царцаахайн аймгууд их ноёныхоо өмнөөс өшөө авах гэж их дайралт хийгээд эдний нийслэл нүхийг маш аюултай сүрдүүлж байгаа гэнэ.

Түмэн нүгэлт царцаахайнууд агаар тэнгэрийг бүрхэн, алтан нарыг халхлан, цасан лавс шиг газар дэлхийг нөмрөн бууж ирээд ургамал, өвс, цэцэг, навчийг уруулаа шилэмдэн шилэмдэн, уухайлж туухайлан идсээр, модны мөчрийг мухар болтол хэмлэсээр, шорвог нуурын усыг хүртэл хаттал залгилсаар айсуй гэнэ.

Шоргоолжны ерөнхий жанжин халуун тогоон дотор суусаар, дайсны довтоллогыг хариулах арга бодлогоо тогтоогоод, тогооноосоо аяндаа гарч толгойгоороо газар хатган гурвантаа тонгоруу харж зогсов. Энэ бол шоргоолж гүрний хүндэтгэлийн хамгийн хүнд ёс гэнэ. Өвгөн жанжин ёсолж гүйцээд хүнд нүсэр дуугаар,





- Баатарчууд минь, эх орон та нарыг энхрий нэрээр чинь дуудаж байна. Эх орон гэгч эрхэм нандин өлгий, нүдний цөцгий шиг энхрий нутгийг минь нүгэлт мангас эзлэх гэж байна. Газар дээр цусаараа бичих шалгалт эхэллээ гэж хэлэхэд,

- Бид шалгалтыг зоригтой угтана гэж шоргоолж цэргүүд уулын чулуу бөмбөртөл хашгирлаа. Газар тэнгэрийг гамшгийн үүл давхар давхар бүрхлээ. Шунахай нүгэлт царцаахайнууд бүдүүн бүдүүн цүлхгэр гэдсээ бөмбөрүүлээд араа шүдээ арзайлган довтолж шоргоолжны улсыг шуудайлан авахаар ирлээ.

Хар голын хоёр эргээр хаант улсын цэргүүд, халдаж ирсэн царцаахайг хашиж аваад байлдлаа. Зургаа зургаан хөлөөрөө зууралдан ноцолдлоо. Нэг хөлийг нь тэвэрч аваад тэнхээ мэдэн мэрлээ. Царцаахай гэдэг аварга мангас шоргоолжны цэргүүдийг арав хориор нь атгаж аваад шидэлж байна. Өдөржин, шөнежин тулалдаж энд тэнд царцаахайн толгой бөмбөрч, шоргоолж цэрэг ч шуурганд налсан өвс шиг газраар нэг зулжээ. Нүгэлт царцаахайн үлдсэн хэд нь дутаан оджээ. Шоргоолж цэргээс нэг зуун тавин мянган цэрэг дайны талбарт баатарлагаар үрэгджээ. Үрэгдэгсдийн дунд өвгөн жанжны шарил харагдана. Шоргоолж улс даяараа дайнд үрэгдсэн өвгөн жанжин тэргүүтэй үй түмэн баатруудаа дурсан гашуудахад хаан бас хар хувцас өмсч гурван өдөр тонгоруугаар гозойж зогсов.

## Арван найм. Сувдын нулимс цувруулан Шоргоолжны хаант улсаас мордов

Би эзэн хаан болон энгийн цэрэгтэй хамт дайны талбарыг цэвэрлэн, үрэгдсэн баатруудын шарилыг онголох ёслолд явтал анх шоргоолжны ордонд ороход уулзсан наян наймдугаар наалинхай хатны шарил байлаа.


Нарийн сайхан нуруу нь найлзуур бургас шиг хугарчээ. Хамгаалж хэвтсэн чулуу нь цусанд будагдан улаан болжээ. Эзэн хаан оршуулгын айлтгалдаа,

- Эрхэм хатан таны амьд сэрүүн цагт чинь хилсдүүлэн гомдоосон хүнд их ослыг минь гэгээн сүнсэндээ уучлан багтааж өршөөмүй. Таны өмнөх хилсдэлийг цагаатган залруулж шоргоолж гүрний мянга есдүгээр хаан миний "Нэр хүндэт нэгдүгээр хатан"-аар нэхэмжлэн өргөмжилье гэж даян дэлхийд зарлан сонордуулав.

Дайн дууслаа. Шоргоолжныхон ялсан боловч тэдний хохирол хүнд байлаа. Нэгэн өдөр шоргоолжны хаан намайг дуудаад,

- Эрхэм та энх манай улсад морилж ирэхдээ "Хамгийн сайхан амтат хүнс хаана байгааг хэлж өгнө" гэсэн бил үү? Одоо онцгой байдал учирсан тул Сул гуай та сурвалжлах ажлаа түр засварлаж, амуу хүнсний аян зөөвөрт замчилж аминд минь орохыг шоргоолж түмний өмнөөс гуйж байна гэж хэлэв.

Би хэдийгээр сурвалжлагын амтанд ороод, есөн мянга есөн зуун есөн шөнө бяцхан найз нартаа ярих үлгэртэй болсон ч хааны зарлигийг арга буюу аялдан дагах боллоо. Шоргоолж, зөгийн аль нь ч болог, итгэл хүндээ алдахыг их цээрлэдэг юм чинь.



Сурвалжлах сонин сайхан өдий төдий үлдсэн ч гэсэн дараа завшаан таарвал та нарынхаа хүслээр сурвалжлагаа баяртай үргэлжлүүлж болох юм.





Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.

